

# Байгалийн Баялгийн Тунхаг

Хоёр дахь хувилбар

# Байгалийн Баялгийн Тунхаг

---

Хоёр дахь хувилбар

# БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ТУНХАГИЙН ШИЙДВЭРИЙН ХЭЛХЭЭ



БАЯЛГИЙН  
ЗАСАГЛАЛЫН  
ДОТООДЫН  
ҮНДЭС



БАЯЛГИЙН  
ЗАСАГЛАЛЫН  
ОЛОН УЛСЫН  
ҮНДЭС

Илрүүлэлт, ашиглах  
шийдвэр гаргах

Сайн нөхцөлөөр  
олборлох

Орлогыг удирдах

Тогтвортой хөгжилд  
хөрөнгө оруулах

- ДҮРЭМ 1  
Стратеги, зөвшил,  
институци
- ДҮРЭМ 2  
Хариуцлага, ил  
тод байдал

- ДҮРЭМ 3  
Хайгуул, лиценз  
олголт

- ДҮРЭМ 4  
Татвар хураалт

- ДҮРЭМ 5  
Орон нутгийн үр  
нөлөө

- ДҮРЭМ 6  
Үндэсний өмчит  
баялгийн компани

- ДҮРЭМ 7  
Орлогын  
хуваарилалт

- ДҮРЭМ 8  
Орлогын  
савалгаа

- ДҮРЭМ 9  
Засгийн газрын  
зарцуулалт

- ДҮРЭМ 10  
Хувийн хэвшлийн  
хөгжил

- ДҮРЭМ 11  
Үндэстэн  
дамнасан  
компаниудын  
үүрэг

- ДҮРЭМ 12  
Олон улсын  
хамтын  
нийгэмлэгийн  
үүрэг

## УДИРТГАЛ

Нөхөн сэргэдэггүй байгалийн нөөц баялагтай улс орны өмнө боломж ба сорилт зэрэг тулгардаг. Хэрвээ зөв ашиглавал, эдгээр баялаг нь одоо болон ирээдүй үеийнхэнд хөгжил цэцэглэлт авчирна; харин буруу ашиглах буюу үрэн таран хийвэл эдийн засгийн тогтворгүй байдал, нийгмийн зөрчилдөөн, хүрээлэн буй орчны үргэлжилсэн доройтолд хүргэж болно.

Байгалийн Баялгийн Тунхаг нь нөөц баялгийг хамгийн зөвөөр удирдахын тулд явуулах бодлогын сонголт, хэрэгжүүлэх практик зөвлөгөөг төр засаг, нийгэм ба олон улсын хамтын нийгэмлэгт санал болгож байна. Баялаг ихтэй улс орнууд өөрт тулгарах сорилтуудыг дангаар сөрөх бус, харин өмнө хуримтлагдсан туршлагаас суралцан, урьд гарсан алдааг давтахаас зайлсхийх боломжийг энэхүү удирдамж олгоно. Тунхаг нь нарийвчилсан жор биш бөгөөд харин байгалийн баялгаас үүдсэн хөгжлийн боломжийг амжилттай ашигласан улс орнууд янз бүрийн нөхцөл байдалд олон арга хэлбэрээр хэрэгжүүлсэн арга туршлагыг судлан харуулна.

Нөөц баялгийн үр ашгийг хүртэхийн тулд тухайн улсын иргэд, тэдний төр засаг өргөн хүрээтэй шийдвэрийг гаргах ёстой. Ийм шийдвэр болгон төр засгаас төвөгтэй хувилбарууд болон алдагдах боломжийг судалж үзэх, мөн эдгээр бодлогын сонголтуудыг хэрэгжүүлэх стратеги боловсруулахыг шаардана. Шийдвэр гаргахад нь төр засагт туслах 12 дүрмийг уг тунхагт тусгав. Эхний 10 дүрэм бол тухайн улс орон ба түүний төр засаг байгалийн баялгаа хэрхэн удирдах талаарх дэлгэрэнгүй удирдамж юм. Харин сүүлийн хоёр дүрэм нь олон улсын оролцогч талууд болох олборлогч компаниуд ба олон улсын түвшний засаглалын байгууллагуудад хандсан болно.

Тунхагт олборлох нөөц баялгийг тогтвортой хөгжил болгон хувиргахын тулд төр засгийн зүгээс харилцан хэлхээтэй бодлогын сайн

шийдвэрүүдийг иргэд, олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэг, хяналтын дор гаргаж, хэрэгжүүлэхэд баримтлах нийт 12 дүрмийг багтаасан юм. Тухайн улс орон олборлосон баялгаасаа бодитой үр ашиг хүртэхийг зорьж байгаа бол энэхүү хэлхээний холбоос тус бүр бат бөх байх учиртай.

### Тунхагийн бүтэц

Тунхагийн дүрмүүдийг гурван бүлэгт хуваасан нь баялгийн засаглалын дотоодын үндэс, баялгийг хөгжил цэцэглэлт болгон хувиргахад шаардагдах эдийн засгийн шийдвэрүүдийн хэлхээ, мөн баялгийн засаглалын олон улсын үндэс юм.

Баялгийн менежментийн түүх урьд нь тааруу байсан хэдий ч зарим улс орон сайн хэрэгжүүлж чадсан байдаг. 1970-1998 оны хооронд баялаг ихтэй, хөгжиж буй 65 улс орноос зөвхөн дөрвөн улс ДНБ-ий 25 хувиас илүү хэмжээтэй урт хугацааны хөрөнгө оруулалтыг татаж, ДНБ-ий дундаж өсөлт нь дөрвөн хувиас давсан байдаг. Эдгээр нь Ботсван, Индонез, Малайз, Тайланд улсууд юм.

*Торвалдур Гилфасон, 2001*

Чиглэл тус бүрээр төр засгийн үйл ажиллагаа харилцан уялдаатай, үр ашигтай байхын тулд Тунхагийн эхний хоёр дүрэмд тусгасан нийтлэг хоёр асуудлыг анхаарах шаардлагатай. Нэгдүгээрт, баялгийг удирдах бүхий л үйл явцыг хамарсан стратеги, чиглүүлэх бодлогыг тэндээс урган гарах дүрэм журам, институцийн иж бүрэн тогтолцооны хамтаар бүрдүүлэхийг Тунхаг чухалчилж байна. Энэ нь Дүрэм 1-д туссан санаа юм. Хоёрдугаарт, эдгээр дүрэм журмууд дагаж мөрдөгдөнө, эсхүл институциуд чадавхитай байсан ч улс орны ашиг тусын төлөө ажиллана гэсэн баталгаа байхгүй. Тиймээс хариуцлагын чанд тогтолцоо шаардлагатай. Баялгийг олборлох орчинд аливаа үйлдлийг нуун

далдлахад хялбар байдаг учраас ийм тогтолцоог бүрдүүлэхэд хүндрэлтэй. Бусад бүх талаар сайтар зохион байгуулагдсан баялгийн удирдлагын тогтолцоонд төр засагт хариуцлага тооцдоггүй явдал нь хэлхээний сул хэсэг болох нь маш элбэг тохиолддог. Дүрэм 2-т үүнийг авч үзнэ.

Тунхаг нь эдгээр нийтлэг асуудлыг авч үзэсний дараагаар олборлолт болон орлогыг тогтвортой хөгжилд зориулах асуудалд чиглэнэ. Дүрэм 3-10-т улс орны шийдвэр гаргах гол асуудлуудыг нэгбүрчлэн авч үзнэ. Эдгээр дүрмийг “эдийн засгийн шийдвэрийн хэлхээ” буюу олборлосон нөөц баялгийн үнэ цэнийг иргэдийнхээ төлөө тогтвортой хөгжил цэцэглэлт болгон хувиргахын тулд төр засгаас гаргадаг шат дараалсан шийдвэр байдлаар боловсруулав. Үүнийг эхлээд хайгуул, илрүүлэлт, дараа нь улс оронд таатай нөхцөлөөр олборлох, улмаар олсон орлогыг удирдах, эцэст нь түүнийг ашиглан урт хугацаанд өгөөжөө өгөх тогтвортой хөрөнгө оруулалт хийх гэсэн шугаман дэс дарааллаар харууллаа. Гэхдээ дүрэм тус бүрт хамаарах асуудлыг бусад хэсгүүдтэй нь холбон авч үзэх бөгөөд бодлогын чиглэл тус бүрийн хувьд эрэмбэ дэс дараа, алдагдах боломж болон чиглэлүүдийн харилцан хамаарлаас үүсэх эрсдэлүүдийг харгалзах шаардлагатай. Эдгээр хамаарал дундуур уншигчийг хөтлөхийн тулд налууулж бичсэн тэмдэглэгээгээр Тунхагийн зохих хэсгүүдийг зааж өгөх юм.

Эдийн засгийн шийдвэр гаргах энэхүү хэлхээний эхлэл нь хайгуул, олборлолт явуулах эрхийг олгох, мөн тэгээд хайгуулыг дэмжих явдал юм. Олборлолт явуулах нь улс орны хувьд хамгийн оновчтой чиг зам эсэхийг шийднэ гэсэн үг юм. Зарим тохиолдолд оновчтой биш ч байж болно. Олборлолт явуулах шийдвэрийг гаргахаас өмнө төр засгаас байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг тооцоолж шийдвэрийн хэлхээг бүхэлд нь нарийвчлан авч үзэх шаардлагатай.

Дараагийн алхам бол улс орон олборлолтоос хүртэх бодит өгөөжийг баталгаажуулах явдал юм. Энэ нь татварын орлого болон бусад үр өгөөжөөр дамжуулан улс орны хүртэх үнэ цэнийг нэмэгдүүлэх тухай асуудал билээ. Түүнчлэн

ойн сан, гол мөрөн, газар зэргийг багтаасан экосистем буюу тухайн улсын байгалийн бусад нөөц баялаг, цаашилбал нийгмийн байгуулалд үзүүлж болзошгүй үлэмж нөлөөллийг бууруулах асуудал хамаарна. Эдгээр сорилтыг Тунхагт “сайн нөхцөлөөр олборлох” гэж нэрлэсэн бөгөөд Дүрэм 4-6-д авч үзнэ.

Эдийн засгийн тогтвортой хөгжил зөвхөн ашигт малтмалыг олборлосноор бий болохгүй тул дан ганц олборлох салбарын асуудлыг авч үзэх нь хангалтгүй. Эрх баригчид олсон орлогоороо ирээдүй хойч үеийнхэн үр шимийг нь хүртэх хөрөнгө оруулалтыг хийх ёстой. Цаашилбал, хэт үрэлгэн зарцуулалтад хүргэж болзошгүй орлогын савалгаат урсгалын эдийн засгийн сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг Засгийн газар авах ёстой. Тус асуудлыг тунхагт “орлогыг удирдах” гэж нэрлэсэн бөгөөд Дүрэм 7-8-д энэ талаар өгүүлэх болно.

Ботсван улс шийдвэр гаргах хэлхээний ихэнхийг амжилттай удирджээ. Тус улсын нэг хүнд ногдох ДНБ (2005 оны тогтмол доллараар илэрхийлсэн дүнгээр) 1980 онд 3,500\$ байснаа 2010 онд 12,500\$ болж өссөн. Гэвч Ботсван нь дэлхийн хамгийн тэгш бус байдалтай бөгөөд ХДХВ/ДОХ-ын хамгийн өндөр тархалттай улс орны нэг төдийгүй эдийн засаг нь олон тулгуурт болж чадаагүй байна. Баялгийн удирдлагатай холбоотой сорилтууд хэвээр үлджээ.

*Олон Улсын Валютын Сан, 2012 он*

Эцэст нь, эрх баригчид байгалийн нөөц шавхагдаж дуусах үед ч тогтвортой үргэлжлэх эдийн засгийн өсөлт, хөгжил цэцэглэлтийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг олборлох салбарын орлогоор хийх ёстой. Сүүлчийн энэ сорилтыг Тунхагт “тогтвортой хөгжилд хөрөнгө оруулах” гэж нэрлэсэн бөгөөд Дүрэм 9-10-д авч үзнэ.

Тухайн улс эдгээр алхмуудыг бүгдийг зөв хийсэн ч олон улсын хамтын ажиллагаагүйгээр баялгийн олборлолтоос тогтвортой, оролцоотой хөгжил цэцэглэлтэд хүрэхгүй байж мэднэ. Тунхагийн

сүүлийн хоёр дүрэмд үндэстэн дамнасан компаниуд, гадаадын төр засаг ба олон улсын түвшин дэх засаглалын байгууллагууд хэрхэн хамтран ажиллаж баялаг ихтэй улс орны иргэдэд туслахыг тодорхойлсон. Энэхүү үүргээ олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс биелүүлэхгүй бол баялаг ихтэй улс орны хамгийн сайн хичээл зүтгэл ч хангалтгүй байж болзошгүй.

Байгалийн Баялгийн Тунхагийг баялаг ихтэй орнуудад тулгардаг сорилтуудыг биеэр мэдэрсэн туршлагатай, олон улсад нэр хүнд бүхий эрхмүүдээс бүрдсэн хяналтын зөвлөлийн

удирдлага дор ажилласан мэргэжилтэн, эрдэмтдийн хараат бус баг бичсэн болно. Энэхүү тунхаг нь аливаа байгууллага, тодорхой ашиг сонирхлыг төлөөлөөгүй. Гагцхүү улс орнууд тулгарах сорилтуудыг даван туулах чадвартай байх тохиолдолд байгалийн нөөц баялаг нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хүргэх хүчирхэг хэрэгсэл болж чадна гэсэн итгэл үнэмшлээр Тунхагийг боловсруулав. Тус болохуйц, ойлгомжтой илэрхийлсэн зөвлөмжүүдийг санал болгохыг зорьсон болно.

# Баялгийн засаглалын дотоодын үндэс



## ДҮРЭМ 1

Баялгийн менежмент нь иргэдэд хүртээх хамгийн их үр өгөөжийг нийтэд хүртээмжтэй бөгөөд иж бүрэн үндэсний стратеги, эрх зүйн ойлгомжтой тогтолцоо болон чадамжтай институциэр дамжуулан баталгаажуулах ёстой.

Баялаг ихтэй улс орнууд баялгаа далайцтай, тогтвортой хөгжил цэцэглэлтэд чиглүүлж ашиглах асар их боломжтой. Харин баялгийн олборлолтыг буруу удирдвал улс оронд ноцтой хохирол учруулна. Ашигт малтмалын баялгийг захиран зарцуулах үүрэг хүлээсний хувьд түүнийг одоо *болон* ирээдүй хойч үеийнхэнд зориулан удирдах нь төр засгийн үүрэг байдаг.

Баялгийг үр дүнтэй, тогтвортой удирдахын тулд нийтэд хүртээмжтэй, иж бүрэн үндэсний стратеги шаардлагатай. Үүний тулд төр засаг хэсэг бүлгүүдэд нөлөө үзүүлэх чухал шийдвэрүүдийг гаргаж алс ирээдүйд ч үр дагавартай сонголтуудыг хийх ёстой. Хагас дутуу шийдвэрээс зайлсхийж, явах зүг чигээ нийтээр ойлголцохын тулд төр засаг оролцогч талуудтай хэлэлцэж, үндэсний стратеги боловсруулах үйл явцад тулгуурлан ашигт малтмалын баялгийг удирдах шийдвэрийг гаргах нь зүйтэй.

### Урт хугацаагаар төлөвлөх

Газрын хэвлийд байгаа нөөц баялгийг нийгмийн өргөн хүрээг хамарсан үр өгөөж болгон хувиргахад олон жил шаардагдах бөгөөд энэ замд олон сорилт, гэнэтийн асуудал тулгарахыг тооцон үндэсний стратегийг урт хугацааг хамруулан боловсруулах хэрэгтэй. Иргэд үр хүүхэд, хойч үеийнхээ аж байдалд санаа тавьж байгаа бол баялгийн олборлолтоос гарах үр ашгийг ирээдүй үеийнхэн хүртэх, дагалдах зайлшгүй сөрөг нөлөөллөөс хамгаалагдах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

### Олон нийтийн оролцоог хангах

Нээлттэй, оролцоог хангасан, нийтэд хүртээмжтэй үйл явцын үр дүнд бий болсон үндэсний стратеги амжилттай хэрэгжих магадлал нь илүү байдаг.

Аливаа төлөвлөгөөг олон нийтээр хэлэлцүүлснээр бодлогын зөрүү, зөрчилдөөнийг түргэн илрүүлж, хувийн эрх ашигт нийцүүлэх болон авлигын үйлдлийг хязгаарлахаас гадна чиг зүгийг залруулахад гарах зайлшгүй өөрчлөлтүүдийн сөрөг нөлөөг багасгадаг. Төр засгийн байгууллага, парламент, олборлолтын шууд нөлөөнд өртөж буй иргэдээс эхлээд иргэний нийгмийн байгууллага, олборлогч компани, хувийн хэвшлийн бизнес эрхлэгчид зэрэг бусад талуудын саналыг нэгтгэн тусгахыг шийдвэр гаргагчдын зүгээс чармайх шаардлагатай. Төлөвлөлтийн шатанд шийдвэрлэх асуудлуудын талаарх зохих ойлголтыг дээрх талууд өгч чадна.

Олборлох ажиллагаа хэдэн үе дамжин үргэлжилж болох тул өнөөдөр гаргаж буй шийдвэр нь төр засаг солигдох мөчлөгөөс үл хамааран тогтвортой байх ёстой. Үүний тулд мэдээлэлтэй иргэдийн хангалттай төлөөллийн хүрээнд ойлголцол, зөвшилцлийг бий болгох шаардлагатай. Хууль тогтоогч, сэтгүүлч, иргэний нийгмийн бүлгүүд зэрэг гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус тоглогчид нь шийдвэр гаргагчдаас хариуцлага нэхэх чухал үүргийг гүйцэтгэснээр тухайн стратегийг хамгаалах юм. *{Төр засгийн хариуцлагатай байдлыг хангахад иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийн талаар Дүрэм 2-оос нэмж үзнэ үү.}*

### Стратегийн цогц байдлыг хангах

Асуудалд цогц хандах нь олборлох салбар дахь үүсгэл санаачилгуудыг төр засгийн зүгээс ойлгож илүү сайн хэрэгжүүлэх үндэс юм. Үүнд, хайгуул, олборлолт ба боловсруулалт явуулахтай холбоотой шийдвэрүүд, хүрээлэн буй орчин ба нийгмийн асуудлууд, засгийн газрын орлогын удирдлага, түүнчлэн эдийн засгийн өргөн хүрээний асуудлуудыг хооронд нь уялдуулах явдал хамаарна.



Энэ үүднээс төрийн байгууллагуудын хувьд уул уурхай, эрчим хүч, санхүү, төлөвлөлт болон бусад чиг үүргийн яамдын хамтран ажиллах орчинг бүрдүүлж, зохицуулалт хийх шаардлагатай. Харилцан хамаарал, давхцал ихтэй сорилтуудыг даван туулахад яамд дундын зохицуулалт чухал. Стратегийн чиглэлийг гүйцэтгэх байгууллагууд шууд гаргах нь оновчтой байж болох ч үүний зэрэгцээ яам бүрийн төлөөлөлтэй нэгдсэн бүтэц зохицуулж хэрэгжүүлэх нь үр дүнтэй байх боломжтой.

Шийдвэр гаргах хэлхээний бүхий л шатанд сайн засаглал шаардлагатай. Ангол улс олборлолтоос их хэмжээний орлого хуримтлуулах замаар хэлхээний эхний хэсгүүдийг сайн удирдсан. Гэвч энэ орлогоо үр дүнтэй, тэнцвэртэй байдлаар удирдан зарцуулж чадаагүй. 2007-2010 онд Ангол улсад 32 тэрбум доллар буюу ДНБ-ий дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний орлого сох дутсан гэж мэдээлэгдсэн байдаг.

*Олон Улсын Валютын Сан, 2011 он*

Байгалийн нөөц баялгийг хөгжил цэцэглэлт болгон хувиргаж чадахгүй байх нь эдийн засгийн зөв бодлого дутсанаас бус, харин засаглалын суурь тогтолцоо сул байхаас хамаарах нь маш элбэг тохиолддог. Тиймээс стратеги амжилттай хэрэгжихэд дан эдийн засгийн талаас нь ойлгох хангалтгүй бөгөөд хариуцлага, төр засгийн институцийн чадвар, бүтэц ба иргэний нийгэмтэй тогтоосон харилцааг чухалчлах ёстой.

### Тодорхой газар нутагт хайгуул хийх эсэхийг шийдвэрлэх

Тухайн улсын нийт газар нутаг, эсхүл тодорхой бүсэд ашигт малтмалын хайгуул, олборлолтыг зөвшөөрөх нь тэр болгон оновчтой байдаггүй. Үйлдвэрлэл явуулж буй бүс нутаг болон улс орны хэмжээнд үзүүлэх сөрөг нөлөө нь эерэг нөлөөнөөс илүү байх боломжтой. Гэсэн хэдий ч нийт иргэдийн хувьд авч үзвэл олборлолтоос бий болох эдийн засгийн үр ашиг нь маш их байх нь элбэг. Тухайн төслийн нутаг дэвсгэрт

гарцаагүй хэрэгжих шийдвэрүүдийг гаргахын өмнө төр засгийн зүгээс стратеги боловсруулах өргөн далайцтай үйл явцын хүрээнд байгаль орчны стратегийн үнэлгээ гэх мэт арга хэрэгслийг ашиглаж байгаль орчны нөлөөллийг тооцох боломжтой. Хэрвээ өртөг хэт өндөр бол байгаль орчны алдагдах үнэ цэнийг нөхөх боломжгүй, эсхүл сөрөг нөлөөлөлд өртсөн иргэдэд зохих нөхвөрийг олгох боломжгүй байж болно. Ийм тохиолдолд улс тухайн ордыг ашиглахгүй байх сонголтыг хийж болно.

Шийдвэр гаргах хэлхээний дагуу өрнөх үйл явцыг удирдах үүрэг бүхий салбар, институциудын чадавхи, бүтцийг ч төр засгийн зүгээс ийм үнэлгээний нэг хэсэг болгон авч үзэх ёстой бөгөөд улсын эдийн засаг, засаглалын тогтолцоо нь их хэмжээний орлогын урсгалыг үр дүнтэй удирдахад бэлэн биш хэмээн дүгнэж болох юм. Ийм тохиолдолд хайгуул болон олборлолтыг цаг хугацааны хувьд дэс дараатай зохион байгуулах нь боломжит нэг хувилбар байх бөгөөд энэ нь төрийн байгууллагын ажилтнууд ачааллаа зөв зохицуулахын хамт туршлагаасаа суралцах боломжийг олгодог.

### Ирээдүй тодорхой бус байхыг тооцон, стратегийг эрт боловсруулах

Төр засаг компаниудтай гэрээ байгуулахаас өмнө лицензийг хэр шуурхай олгох, татвар ногдуулах, мөн эрх зүйн ямар орчин бүрдүүлэх зэрэг олон асуудлаар шийдвэр гаргах ёстой. Цаашилбал, эдгээр шийдвэрийг ирээдүй тодорхой бус нөхцөлд гаргах болдог. Тиймээс улс орнууд стратеги боловсруулах үйл явцыг аль болох эрт эхлүүлэх хэрэгтэй; энэ нь гаргах шийдвэрийг чиглүүлэх ёстойгоос гадна нөхцөл байдал өөрчлөгдөхөд түүнд зохицуулж болохуйц байх шаардлагатай.

### Стратегийг тодорхой бөгөөд харилцан уялдаа бүхий институцийн хүрээ болгон хувиргах

Оролцогч талуудын зан үйлдлийг тодорхойлж байдаг дүрэм журам, үүрэг хариуцлага болон институциуд нь баялгийн оновчтой менежментийг хэрэгжүүлэх үндэс юм. Нэн тодорхой, харилцан

уялдаатай дүрэм журмыг боловсруулж, зохион байгуулж, хэрэгжүүлэх чадварлаг институцийн хамтаар стратегийн удирдамж бодлогыг бий болгох нь гол сорилт байдаг. Төрөөс олборлох салбарын өвөрмөц бөгөөд өөрчлөмтгий орчинг харгалзан ийм тогтолцоог бий болгож, улс орныхоо эдийн засаг, институцийн онцлогтой уялдуулан ажиллуулах шаардлагатай.

Компаниудад олборлолт болон хайгуул хийх зөвшөөрөл олгож эхлэхээс өмнө төр засгийн зүгээс хууль эрх зүйн болон зохицуулах бүтцийг аль болох бүрдүүлсэн байх шаардлагатай. Ингэснээр компаниудтай холбоотой шийдвэр гаргах чадавхитай засаглалыг бүрдүүлэхээс гадна компаниудын үйл ажиллагаа явуулах дүрэм журмыг зохих баталгаатай болгодог. Нөхцөл шаардлагыг хуулиар тогтоож өгөх нь дур зоргоор шийдвэр гаргахыг хязгаарлаж, ил тод байдлыг нэмэгдүүлэх хэдий ч тухайн салбар хөгжихийн хэрээр өөрчлөгдөх нөхцөл байдалд дүрэм журмыг тохируулах боломжийг хязгаарлаж болзошгүй. Хууль тогтоомж, гэрээ хэлцлийн хажуугаар төрийн байгууллагуудын олборлох салбарын зохицуулалтыг хийх эрхийг хангах хэрэгтэй. Зохих чадавхи, хяналт бүхий зохицуулагчид нөхцөл байдлын өөрчлөлтийг тооцсон дүрэм журмыг боловсруулж, хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулаагүй асуудлыг шийдвэрлээд явах боломжтой.

## Нэгдмэл зорилготой чадварлаг институциуд бий болгох

Институци тус бүрийн хувьд үндэсний стратегийн төлөвлөгөөг дэмжихүйц, логик уялдаатай зорилтыг төрөөс тогтоож өгөх ёстой. Цаашилбал эдгээр институциудын үйл ажиллагаанд олон нийт, гүйцэтгэх засаглал, ерөнхий аудиторын зүгээс тавих хяналтыг төрийн зүгээс баталгаажуулах хэрэгтэй. Сонирхлын зөрчил үүсэх, үүрэг хариуцлага орхигдохоос зайлсхийхийн тулд институци нэг бүрийн чиг үүргийг нарийн тогтоох шаардлагатай. Дүрэм журмыг хэн гаргах, түүнийг хэн зохион байгуулах, хэн хэрэгжилтийг хангахыг тодорхой

байлгах нь маш чухал. *{Дүрэм 6-аас үндэсний компаниудын чиг үүргийн хуваарийн талаар нэмж үзнэ үү.}*

Ялангуяа олборлох салбарт төр засагтай хэлцэл хийгч талууд ихэвчлэн нарийн мэргэшсэн компаниуд байдаг учраас төрийн институцийн чадварыг бий болгож хадгалах нь хэдий бэрхшээлтэй ч маш чухал. Энэ сорилтын нэг хэсэг бол холбогдох институцэд чиг үүргийг хуваарилахдаа шагнал, нэр хүндийн илрэл болгож бус, шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэх явдал юм. Жинхэнэ мэргэжлийн чадварыг хөгжүүлэх төгс шийдэл нь төрийн албан тушаалтнуудын гаргаж буй хүний нөөцийн шийдвэрүүд нь хараат бус, улс төрийн нөлөөллөөс ангид байх явдал мөн. Чадварыг харгалзан урамшуулах тогтолцоо, хүний нөөцийн нухацтай бодлого нь төрийн мэргэшсэн үйлчилгээний соёлыг нэвтрүүлж үр ашигтай болгож чадна.

Эцэст нь, төрийн институциудад тулгарч болох томоохон сорилтуудын нэг бол шилдэг, мэргэшсэн боловсон хүчнээ хадгалж үлдэх асуудал юм. Хувийн хэвшил ба төрийн өмчит олборлох үйлдвэрийн газрууд ч гэсэн авьяаслаг албан хаагчдыг татах чадвартай бөгөөд тэд давуу нөхцөлтэй саналыг хүлээн авснаар төрийн институциудын хүний нөөц байнга шавхагдаж байдаг. Цалин, урамшууллын зорилтот багц, төрд алба хааж байсан бол хожим эргэн ирж ажиллах боломж, мөн төр засгийн байгууллагуудад ажил мэргэжлийн соёлыг сайжруулах нь энэ асуудлыг

Олборлох салбар дахь ил тод байдал дэлхийн хэмжээнд сул байна. Баялгийн Засаглалын Индексийн хүрээнд судалсан 58 улс орноос ердөө 10 нь л газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын гэрээ, лицензийг ил тод нийтэлдэг. Харин сүүлийн үед ил тайлан гаргаснаар Афганистан, Гана, Гвиней зэрэг улс ийм улсын тоог нэмэгдүүлж байна.

*Орлогын Ажиглагч Хүрээлэн, 2013 он*

## ДҮРЭМ 2

Баялгийн засаглал нь шийдвэр гаргагчдыг мэдээлэл бүхий олон нийтийн өмнө ажлаа тайлагнаж, хариуцлага хүлээдэг байхыг шаарддаг.

Иргэдийн өмнөөс байгалийн нөөц баялгийн удирдлагыг хэрэгжүүлдэг төр засаг хариуцлага хүлээдэг байсан цагт тогтвортой хөгжилд хүрэх боломжтой. Зан үйлдлийг байнга хянах нь авлигаас сэргийлэх хүчтэй арга болоод зогсохгүй төр засгийн бүх шат түвшинд гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг юм. Цаашилбал өнөөгийн болон ирээдүйн төр засгууд тавьсан зорилтуудаа энэхүү хяналттай холбож чадвал эрдэс баялгийг удирдах үндэсний стратеги ирээдүйд ч үр ашигтай байх болно.

### Шийдвэрийн хэлхээний бүх хэсэгт мэдээллийн ил тод байдлыг хангах

Эдийн засгийн бусад үйл ажиллагаатай харьцуулахад баялгийн олборлолт ба түүнээс олох орлогын удирдлага нь ихэнх иргэдийн өдөр тутмын амьдралаас хол байдаг. Авлигын нөхцөлийг бүрдүүлж, муу менежментийг далдалснаар шийдвэрийн хэлхээг хянахад хүндрэлтэй байж болзошгүй.

Хариуцлагатай байдлын хамгийн чухал урьдчилсан нөхцөл бол ил тод байдал юм. Гэхдээ бүрэн бус мэдээлэл хангалтгүй. Төр засгаас шийдвэрийн хэлхээний бүхий л хэсгийн мэдээллийг иж бүрнээр, нэмэлт мэдээллийн хамт нээлттэй болгох ёстой. Жишээ нь, орлогын баримт мэдээнд татварын хувь хэмжээ болон татвар ногдуулах орлогын талаарх мэдээллийг дагалдуулж болно. Ийм мэдээллийг байршил, төсөл, бүтээгдэхүүний төрөл зэрэг зохистой нарийвчлалтайгаар нийтлэх нь зүйтэй. Дээрээс нь харилцан тохирсон, харилцаж ажиллах стандартад нийцсэн “машинаар уншигдах өгөгдөл” (компьютер автоматаар ашиглах боломжтой, тайлбар тодорхойлолт бүхий өгөгдөл) байх нь хяналт мониторинг хийхэд тустай. Цаашилбал

эрдэс баялгийн төсөлд өрсөлдөж байгаа болон хөрөнгө оруулж байгаа, төслийг хэрэгжүүлж байгаа компаниудын нэрсийг тэдгээрийн ашиг хүртэгч өмчлөгчдийн мэдээллийн хамт нийтлэх нь мониторинг хийх болон татварын холбогдох дэглэмийг хэрэгжүүлэхэд ашиг тустай.

Улсын өмчит баялгийн компаниудын үйл ажиллагаа наанадаж хувийн компаниудтай ижил хэмжээнд ил тод байх шаардлагатай. Эдгээр компаниудын стратеги, зарцуулалтын төлөв мөн ил тод байх ёстойгоос гадна илүү ч нээлттэй ажиллахыг нийтийн эрх ашиг шаардаж болох юм.

Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл, геологийн судалгаа, кадастр, нөөцтэй холбоотой тайлан мэдээллийг, түүнчлэн эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг нийтлэх хэрэгтэй. Хамгийн чухал нь тэдгээр байгууллага гэрээнүүдээ нийтэлж интернэтээр хүртээмжтэйгээр байршуулах шаардлагатай.

Мөн салбарын удирдлага, орлогын удирдлага ба зарцуулалтын талаар дотоодын бүртгэл хөтлөх, хяналт тавих боломжийг олгох мэдээллийг нээлттэй болгох шаардлагатай. Ийм мэдээллийг төр засгаас гаргасан төсвийн дүрэм журамтай тулган үзэх боломжтой. Цаашилбал, төсвөөс гадуур үйл ажиллагаа явуулж болзошгүй тул хуримтлалын сангуудыг ил тод тайлагнах хатуу шаардлага тавигдах ёстой. Сангийн удирдлага нь нэн ялангуяа тайлан баланс, мөнгөн урсгал, төлбөр хүлээн авагч ба аудитын мэдээллийг нийтлэх ёстой.

Төр засгийн зүгээс төлбөр, зарцуулалтын мэдээлэл төдийгүй шийдвэр гаргах хэлхээний бүх үе шатанд үйлчлэх дүрэм журмуудыг нийтлэх ёстой. Олон тохиолдолд ийм дүрэм

журмын томоохон хэсгийг олон нийтийн хараа хяналтаас далд нарийн төвөгтэй гэрээ хэлцлүүдэд тусгасан байдаг. Гэрээ хэлцэлтэй харьцуулахад ажиглагчид нягтлах боломж илүү учраас төр засгийн зүгээс тодорхой нөхцөлүүдээ аль болох хууль тогтоомжид суулгаж өгөх шаардлагатай. Хууль тогтоомжид зааснаас ухарсан аливаа нөхцөлийг гэрээгээр тохиролцсон бол хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлж, батлуулах хэрэгтэй. Нэн тэргүүнд нууцлалын заалтыг гэрээнд оруулахаас зайлсхийж, гэрээг олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай.

Олон нийтийн мэдээлэл авах эрх нь үндэсний ба олон улсын олон конвенцоор хамгаалагдсан байдаг бөгөөд хуулиар тусгайлан хориглосноос бусад төр засгийн бүх мэдээлэл ил тод байх шаардлагыг хуульчилсан улс орны тоо нэмэгдсээр байна. Иргэдэд нөлөөлөх гэрээ хэлцлийг тэд өөрсдөө нягтлан судлах боломж олголгүйгээр баялгийг олборлох эрхийг бусдад шилжүүлэх эрсдэлийг бууруулах дүрэм журмыг төр засгаас гаргах ёстой.

Илүү сайн ил тод байдлын ач тусыг төр засаг ба бизнес эрхлэгчид ч хүртэнэ. Ил тайлагнах шаардлагууд нь мэдээллийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх хөшүүрэг болж, улмаар чухал мэдээ мэдээллийг цуглуулж хадгалах өртгийг бууруулж, түүний үнэн зөв байдлыг сайжруулах юм. Энэ нь төр засгийн үйл ажиллагаа үр ашигтай байхад нэн чухал. Тухайлбал, удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах мэдээллээр хангаж, компани, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах ба төр засгийн дотоод хариуцлагын чанд тогтолцоог дэмжих юм. Үүнээс гадна компаниуд өөрийн үйл ажиллагааны салбартаа олон нийтийн хүлээлтийг удирдах сорилттой тулгардаг бөгөөд үр дүнтэй ил тод байдлыг хангаснаар үл итгэх явдлыг багасгаж, “үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл”-ийг бэхжүүлдэг.

### Институциудын чиг үүргийг тодорхой тогтоож өгөх

Хэрэгжүүлэх чиг үүрэг, зан үйлдлийн стандартыг тодорхой, бүгдэд ойлгомжтой тогтоож өгснөөр

төр засгийн үйл ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавьж чадна. Аливаа шийдвэр гаргах явцыг эрх бүхий албан тушаалтнуудад хандсан нийгмийн хүлээлтийг тусгасан, хууль тогтоомжоор баталгаажсан үнэт зүйлс, ёс зүйн багц стандарт чиглүүлж байх учиртай

Хэрвээ хариуцлагыг тодорхой зааглаж, үүргээ биелүүлээгүй институцийг гүйцэтгэх засаглалын болон хөндлөнгийн аудит зэрэг байгууллагууд хянаж хариуцлага тооцож чадвал төр засаг илүү сайн ажиллана. Цаашилбал гүйцэтгэлийг сайжруулах шаардлагын дагуу арга хэмжээ авахын тулд төр засгийн институциуд үр дүнтэй шийдвэр гаргах чадамжтай байх ёстой. Засаглалыг сайжруулья гэж байгаа нөхцөлд хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийн тулд чадавхийг бэхжүүлэх шаардлагатай. *{Мөн Дүрэм 1-ээс чиг үүрэг, хариуцлагын хүрээ, институциудын чадавхийн талаар үзнэ үү.}*

### Сайн засаглалыг шаарддаг мэдээлэлтэй иргэдийн хангалттай төлөөллийг дэмжих

Мэдээллээр хангах нь уг мэдээллийг ашиглаж төр засгийн үйл ажиллагааг хянах, үнэлэх чадвартай хослох ёстой. Шашин, шинжлэх ухаан, мэргэжлийн болон нийгмийн чиглэлийн байгууллагууд, түүнчлэн хэвлэл мэдээлэл үүнд чухал үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр байгууллагууд үр дүнтэй байхын тулд төр засгаас хараат бус байж, санхүүгийн эх үүсвэр болон төлөөлж буй ашиг сонирхлын талаарх мэдээллээ нээлттэй байлгах ёстой. Төр засаг өөрийн зүгээс иргэний нийгэм, тэр дотроо хэвлэл мэдээллийн байгууллагын эрхийг тодорхойлж хамгаалах, тэд дарамт шахалтгүйгээр ажиллах боломжийг олгох ёстой.

Гүйцэтгэх засгийг хянахад хууль тогтоох байгууллага нэн чухал үүрэгтэй. Төр засгийн болон бусад байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна олон нийтэд тулгамдсан асуудлыг дамжуулагч болж өгдөг. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоох байгууллага нь олборлох салбарын асуудлаар ойлголт, чадавхи сайтай байх, ашигт малтмал олборлолтын менежментийн учир начрын талаар найдвартай зөвлөгөө авдаг байх ёстой.

Иргэд мэдээлэлтэй байвал үндэсний стратегийн чиг баримжааны талаар төр засагтай хэлэлцэх ч боломжтой. Бас баялгийн засаглалын асуудал нь иргэдийн хувьд нэн чухал байх тул олон нийтийн хүлээлтийг удирдан зохицуулах нь маш чухал. Энд төр засаг ба иргэний нийгэм хоорондоо үр дүнтэй харилцах стратеги, холбоо хамаарал шийдвэрлэх үүрэгтэй.

Шийдвэр гаргах хэлхээний хэсэг бүрд хууль тогтоох байгууллагын хяналт сул байгаа нь тодорхой болсон. Баялгийн Засаглалын Индексээр судлагдсан Ботсвана, Өмнөд Тимор зэрэг 31 улс оронд гэрээ байгуулах, лиценз олгох үйл явцад хууль тогтоох байгууллага нь тун бага хяналт тавьдаг бол 29 улс оронд баялгийн орлогод тавих хяналт маш хязгаарлагдмал байна.

*Орлогын Ажиглагч Хүрээлэн, 2013 он*

## Дүрэм журмын хэрэгжилтийг хангах

Эцэст нь, төр засаг үйл ажиллагааг хянах арга хэрэгсэлтэй байж, хажуугаар нь шийтгэл ногдуулах үүрэг хүлээж, үүний тулд зөрчил гаргагчдыг шийтгэх улс төрийн зориг ба чадвартай байх ёстой. Ингэхийн тулд итгэл хүлээсэн, хараат бус шүүхийн тогтолцоо юу юунаас чухал юм. Шүүх сайн ажиллах боломжгүй бол авлига үүсэх, гэмт үйлдэл гарах боломж нэмэгдэнэ.

# Илрүүлэлт ба ашиглах шийдвэр гаргах



## ДҮРЭМ 3

Төр засаг нь үр ашигтай хайгуул ба ашиглалтын үйл ажиллагааг дэмжиж, түүний эрхийг ил тод олгох ёстой.

Үндэсний цогц стратегийн хүрээнд хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах, хууль, эрх зүйн орчныг аль болох эртнээс бүрдүүлэх нь төр засагт тулгарах сорилт юм. *{Дүрэм 1-ээс Баялгийн үндэсний стратеги, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх тухай хэсгийг мөн үзнэ үү.}*

### Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдох газар нутгийн өмчлөлийн эрхийг нягтлах

Улс орны төр засгийн зүгээс хайгуул явуулахаар төлөвлөж буй газар нутагт маргашгүй эрхтэй гэдгээ нягтлах шаардлагатай. Энэ нь өөрийн төдийгүй хөрш улс орныг хамаарч болох ба хил дамнасан илэрцийг хамтран ашиглах шаардлага ч гарч болно.

### Баялгийн нөөцийн талаар сайн мэдэж ойлголтоо сайжруулж байх

Төр засгийн албан тушаалтнууд улс орныхоо баялгийн нөөц, түүний хэмжээ болон газарзүйн тархалтын талаар бүрэн дүүрэн ойлголттой болох ёстой. Ашигт малтмалын нөөцийн хэмжээ нь олборлох хурдац, ирээдүйн боломжит орлогын талаарх чухал шийдвэр гаргахад хэрэгтэй. Харин газарзүйн байршлын мэдээлэл тухайн улсын нутаг дэвсгэрт өмчийн эрх тогтоох, хайгуулын лиценз олгох асуудал болон цаашид байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодруулж өгдөг.

Тусгай зөвшөөрөл олгохоос өмнө төр засгийн эсхүл гадны хандивлагчдын санхүүжилтээр геологи, геофизикийн судалгаанд хөрөнгө оруулах нь түүний үр дүнд цугласан мэдээлэл геологийн талаасаа хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, улмаар тэдний зүгээс үнийн өндөр санал ирүүлэхэд хүргэх аваас төр засгийн хувьд өндөр

өгөөжтэй хөрөнгө оруулалт юм. Харин геологийн нөхцөл нь ашигт малтмал илрэхэд таатай бус гэж тогтоогдвол хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нь буурч болох юм.

Төр засаг нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрт явагдсан аливаа хайгуулын үр дүнд бий болсон техникийн шинжтэй мэдээллийг цуглуулж, хадгалж, түүнд дүн шинжилгээ хийх үүрэгтэй. Ийм мэдээлэл геологийн нөхцөл байдлыг төр засаг ойлгоход чухал бөгөөд хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх байр суурийг бэхжүүлэхээс гадна тусгай зөвшөөрлийн тогтолцоог оновчтой болгоход тустай. Ийм учраас хөрөнгө оруулагчид техникийн шинжтэй бүхий л мэдээллээ ойлгомжтой хэлбэрээр гаргаж өгөх нөхцөлийг төр засгийн зүгээс бүрдүүлэх хэрэгтэй.

### Хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой газруудыг тогтоож, өмчийн эрхийг баталгаажуулах

Зөвшөөрөл олгохоосоо өмнө төр засаг нь хайгуул хийгдэх тухайн газар нутагт олборлох баялаг хийгээд бэлчээр, ус зэрэг гадаргын баялгийн өмчийн эрхийг үндэснийхээ хууль тогтоомжийн хүрээнд тогтоож өгөх шаардлагатай. *{Дүрэм 5-аас байгаль орчны дүн шинжилгээ ба байнгын хяналтын тухай хэсгийг мөн үзнэ үү.}*

Эрх бүхий байгууллага нь олборлолт явуулах боломжтой орд газрын геологийн нөхцөл, хэмжээ, байршил зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр хайгуулын лицензийн талбай ба хил хязгаарыг нарийн тогтоох хэрэгтэй. Геологийн нөхцөл байдлыг нарийн тогтоогоогүй байдаг учраас хайгуулын ажлын эхний үе шатанд лицензийн талбай ихэвчлэн маш том байдаг. Аль нэг лицензийн талбайд баялгийн нөөц хэт

их хэмжээтэй ногдохоос сэргийлэх үүднээс хайгуулын явцад лицензийн талбайг багасгах боломжийг лиценз олгох тогтолцоонд суулгах хэрэгтэй. Шинэ нөөц илэрснээс үүдсэн газрын үнэ цэнийн өсөлтийн үр шимийг төр засаг хүртэх боломжтой байхын тулд эрх бүхий байгууллага нь лицензийг эрэмбэ дэс дараатайгаар олгоход анхаарах ёстой.

Эцэст нь, олборлолтын үйл ажиллагаанаас бий болох агаарын бохирдол гэх мэт байгаль орчны эрсдэлийг төр засаг хүлээгдэж буй үр өгөөжтэй харьцуулан дэнслэх шаардлагатай. Байгаль орчин, нийгмийн хувьд эмзэг газруудад хайгуул явуулахаас зайлсхийх эсхүл эдгээр эрсдэлийг бууруулах алхмуудыг хийх шийдвэрийг төр засаг гаргах ёстой.

Сүүлийн үед илрүүлсэн ордууд нь маш их өөрчлөлт авчрах боломжтой. Гвиней улс дахь төмрийн хүдрийн Симандоу төсөл, Либери улс дахь төмрийн хүдэр, газрын тосны төслүүд нь тухайн улсдаа жилд дунджаар 1.6 тэрбум долларын буюу 2011 оны ДНБ-ийх нь 31 ба 147 хувьтай тус бүр тэнцэх хэмжээний орлого оруулах боломжтой юм.

*Африкийн Дэвшил Зөвлөл, 2013 он*

## Эрх олгох тохиромжтой аргыг сонгох

Төрөөс хэн, ямар нөхцөлөөр хайгуулын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахыг шийдвэрлэх ёстой. Хэрэв төр засаг хувийн хэвшлийн компаниудыг оролцуулах бол тусгай зөвшөөрөл тус бүрээр шууд хэлэлцээ хийж, эсхүл өрсөлдөөнт шалгаруулалтын үндсэн дээр нэг эсхүл хэд хэдэн лиценз олгож болно. *{Дүрэм 6-аас үндэсний өмчит компаниудын хэрэгжүүлж болох чиг үүргүүдийн тухай хэсгийг мөн үзнэ үү.}*

Сайн төлөвлөсөн дуудлага худалдаа давуу талтай, учир нь үнийн саналаар өрсөлдүүлснээр улсад илүү ашигтай байх ба гадаадын компаниудтай харьцуулахад төр засаг мэдээллийн хомсдолтой байх явдлыг шийдэхэд тусална. Дуудлага

худалдаа нь шууд гэрээний аргатай харьцуулахад илүү нээлттэй тул хайгуул, ашиглалтын эрхийг шаардлага хангахгүй компани, хувь хүмүүст олгох эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Дуудлага худалдаа амжилттай болох эсэх нь хамгийн багадаа гурван оролцогч санал ирүүлсэн байхаас шалтгаална. Дуудлага худалдаанд хангалттай санал ирэхгүй бол өрсөлдөөнт шалгаруулалтын арга засгийн газрын хувьд зөв сонголт биш гэсэн үг. Газрын тосны гэхээс илүүтэйгээр ашигт малтмалын салбарт геологийн нөхцөлийн талаар хангалттай мэдээлэл байхгүй байх нь элбэг ба ийм үед дээрх нөхцөл үүсдэг. Дуудлага худалдаанд хангалттай өрсөлдөөн байхгүй тохиолдолд төрийн зүгээс техникийн наад захын хатуу шалгуурыг тогтоож, нэг үе шаттай сонгон шалгаруулах аргыг хэрэглэх нь тохиромжтой.

Эрх олгох ямар аргыг ашиглахаас үл хамааран төр засгийн байр суурийг бэхжүүлэхэд туслах хэд хэдэн зарчим бий. Засгийн газрын зүгээс эрх олгох журам, байгуулсан аливаа гэрээ, түүнд туссан санхүү, татварын нөхцөлүүд, нийт лиценз эзэмшигчдийн ашиг хүртэгч өмчлөгчид, харилцан тохиролцсон ажлын хөтөлбөр, мөн тусгай зөвшөөрөлд хамааралтайгаар хүлээх санхүүжүүлэх үүрэг болон татварын аливаа нөхцөлийн талаарх мэдээллийг ил нийтлэх шаардлагатай.

Шалгаруулалтад оролцогч компаниудыг төрөөс урьдчилан шалгаруулж баялгийг ашиглах бүтээн байгуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн болон санхүүгийн хангалттай чадавхитай бөгөөд төсөл болон холбогдох дэд бүтцийн улмаас үүсэж болох байгаль орчны эрсдэлүүдийг удирдах зохих туршлагатайг багалгаажуулах ёстой. Мөн талууд хамтарч санал гаргахыг дэмжих эсэх, түүнчлэн тодорхой лицензээс талуудын эзэмших хувь хэмжээг тогтоох эрхийг хадгалж үлдэх эсэхээ төр засаг шийдвэрлэх шаардлагатай. Гуравт, төр засаг тендерийг цөөн тооны нөхцөлөөр хязгаарлах замаар ирсэн саналуудыг хооронд нь тодорхой харьцуулах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.



Үүнд ажлын төлөвлөгөө, гарын үсэг зурсны урамшуулал, дотоодоос ханган нийлүүлэлтийн нөхцөлүүдийг хамруулж болно. Уралдаант шалгаруулалт, хэлэлцээр нь дан ганц олборлох эрхийн үнэ төлбөрт төвлөрөх шаардлагагүй хэдий ч нөгөө талаас хэт олон хувьсагчийг авч үзэх нь ээдрээг нэмэгдүүлэх, үнэлгээний явцын ил тод байдлыг бууруулах, бас захиргааны зардлыг өсгөх талтай. Дөрөвт, компаниуд тендерт саналаа ирүүлсний дараа тэдэнд тодорхой нөхцөл тавьж хэлэлцэх шаардлагагүй байхыг төр засгийн зүгээс хангахыг хичээх ёстой. Шалгаруулалтын нөхцөлүүд тодорхой бөгөөд ил тод байх, мөн загвар гэрээг ашиглах нь үүнд тусална.

Эцэст нь олборлох эрхийг тодорхой үйлчилгээ, дэд бүтцийн бартерийн хэсэг болгон солилцож байгаа тохиолдолд тэдгээрийн үнэлгээг анхааралтай тооцоолох хэрэгтэй. Үнэлгээ нь тийм ч тодорхой биш бол төрийн зүгээс ийм төрлийн хэлцлээс зайлсхийх шаардлагатай. Бартер хэлцэл нь ихэнхдээ хаалттай байдаг бөгөөд авилгын эрсдэлийг нэмэгдүүлж байдаг.

### Бүтээн байгуулалтын төлөвлөгөөг төр засгийн зорилгод нийцүүлж, улмаар цаг хугацаа алдалгүй батлах

Эдийн засгийн хувьд ашигтай баялгийг нээж, түүний үнэлгээг хийсний дараа лиценз эзэмшигч нь засгийн газар, түүний агентлаг, зарим тохиолдолд хууль тогтоох эрх мэдлийн байгууллагаар батлуулах зорилгоор олборлох ажлын төлөвлөгөөг боловсруулна. Олборлолтын төлөвлөгөө нь зардлын хувьд үр ашигтай бөгөөд нөөц шавхагдах, дэд бүтцийг ашиглах, эрүүл

мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, дотоодоос бараа үйлчилгээ ба ажиллах хүч нийлүүлэх асуудлаарх бодлогын зорилтуудад нийцэхийг баталгаатай болгох ёстой. Үүнээс гадна төслийн талбайг орхихдоо хийх цэвэрлэгээ, нөхөн сэргээлт зэрэг ажлыг төлөвлөгөөнд мөн тусгасан байх ёстой.

Засгийн газар эдгээр төлөвлөгөөг хугацаанд нь, гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг хариуцлагад нийцүүлэн бүрэн хянаж үзэх хэрэгтэй. Үүний тулд шаардлагатай үед мэргэжлийн хангалттай мэдлэг, туршлагатай байж, холбогдох яам, агентлагуудын уялдаа зохицуулалтад тулгуурлаж төлөвлөгөөг батлах үр дүнтэй үйл явцыг хангах ёстой. *{Дүрэм 5-аас Төслийн бүтээн байгуулалтын төлөвлөгөөний байгаль орчин, нийгмийн асуудлууд, Дүрэм 10-аас дотоод агууламж, дэд бүтцийн талаарх хэсгийг тус тус үзнэ үү.}*

### Биет баялгийн бүртгэлийг хөтлөх

Үйлдвэрлэлийн хэмжээ, батлагдсан нөөц болон тодорхой бус байдлын төлөв, илрүүлсэн баялаг, цаашид хайгуул хийх боломж зэрэг мэдээллийг багтаасан биет баялгийн бүртгэлийг хөтлөх нь салбарын бодлого боловсруулах, зохицуулалт хийх үндэс суурь болж өгдөг. Ийм бүртгэл болон олборлолттой холбоотой орлого, зардлын мэдээлэл нь ирээдүйд засгийн газарт хэдий хэмжээний орлого орж ирэх боломжтой, үүнээс хэдийг хадгалах шаардлагатай, мөн хайгуулын ажлын хурдац ямар байхыг харуулдаг. Эцсийн дүндээ баялгийг ашигласны үр шимийг дээд хэмжээнд хүргэхэд төр засагт тусална.

# Сайн нөхцөлөөр олборлох



## ДҮРЭМ 4

Татварын дэглэм болон гэрээний нөхцөлүүд нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсанаар баялгийн үр шимийг бүрэн хүртэх боломжийг төр засагт олгосон, мөн нөхцөл байдлын өөрчлөлтөд тэсвэртэй байх шаардлагатай.

Байгалийн баялгийг ашиглах нь ажлын байр гэх зэрэг өгөөжтэй ч хамгийн гол үр шим нь хөгжил, иргэдийн аж амьдралыг дэмжихэд ашиглах төр засгийн орлогыг бүрдүүлэхэд оршино. Энэхүү орлогыг бий болгохын тулд олборлох баялгийн мөн чанар, ашиглалтыг дагалддаг ихээхэн тодорхойгүй байдал, төр засгийн чадавхи зэргийг харгалзсан, сайтар загварчилсан санхүү, татварын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Тус салбарын чухал тодорхойлолтууд гэвэл,

- Хангалттай “өндөр ашиг”-тай байх буюу хөрөнгө оруулагчид гаргасан зардлаа нөхөж хамгийн багаар тооцсон ашиг олохоос давж гарсан өгөөжтэй байх
- Орд газрын нөөц баялаг шавхагдах
- Төр засаг болон боломжит хөрөнгө оруулагчид тэгш бус мэдээлэлтэй байх
- Эхлэлтийн зардал өндөр ба олборлолтын хугацаа урт байснаар зах зээл, геологи болон улс төрийн нэн тодорхойгүй нөхцөлд урт хугацаатай хөрөнгө оруулалт шаардагдах
- Санхүү, татварын хяналт тавихад шаардлагатай (хөрөнгө оруулагч нь төр, эсхүл хувийн хэвшлийн байхаас үл хамааран) нягтлан бодох бүртгэл, аудитын орчин бэрхшээлтэй байх

Төрийн зүгээс эдгээрийг харгалзан өөрийн баялгаас хангалттай өгөөжийг боломжийн хугацаанд авч, мөн тодорхойгүй байдал, эрсдэл ба үр ашгийн тэнцвэрт харьцааг бодолцон санхүү, татварын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд баялгийг ашиглах нь оновчтой гэж үзвэл зохих хөрөнгө оруулалтыг татах хэрэгтэй болдог. Цаашилбал улс орнууд өмчлөл болон татварын хэлбэр, бүтцэд нөлөөлж болзошгүй

эрх зүйн өөрийн уламжлал, үндсэн хуулийн хязгаарлалтуудыг ч харгалзан үзэх ёстой.

### Татварын дэглэмийн хэлбэрийг бус чиг үүргийг анхаарах

Дээрх шаардлагуудыг бодолцвол хөгжиж буй орнуудад татварын сайн дэглэмийг бүрдүүлэхдээ үйлдвэрлэл явагдах хугацаанд төрийн наад захын орлогын урсгалыг хангах нөөц ашигласны төлбөр болон бүтээгдэхүүнд суурилсан бусад төлбөр, мөн ашгийн болон хэвийн хэмжээнээс давсан ашгийн тодорхой хэсгийг хуваалцах механизм гэх хоёр суурь хэсгийг бүрдүүлэх хэрэгтэй.

Татварын дэглэм нь нэр томьёо, эрх зүйн хэлбэрийн хувьд өөр өөр байж болох хэдий ч ихэнхдээ дээрх хоёр зүйлийг агуулдаг. Ашигт малтмал ба газрын тосны салбарт хоёуланд нь хэрэглэгддэг “татвар ба нөөц ашигласны төлбөр” хэмээх тогтолцоонд хөрөнгө оруулагчид бүтээгдэхүүнээсээ нөөц ашигласны төлбөрийг төр засагт төлөөд дээр нь олсон ашгаасаа энгийн орлогын татварыг төлдөг. Голдуу газрын тосны салбарт хэрэглэгддэг ч уул уурхайг ч хамаарч болох “бүтээгдэхүүн хуваах” зохицуулалтын хувьд бүтээгдэхүүний тодорхой хэсгийг хөрөнгө оруулагч буюу гэрээт компанийн гаргасан зардлыг нөхөхөд (“өртөгт тос”) зориулж, харин үлдэх хэсгийг (“ашигт тос”) засгийн газар болон хөрөнгө оруулагчид хоорондоо хуваадаг. Татвар ба нөөц ашигласны төлбөр болон бүтээгдэхүүн хуваах зарчмаас өөр нэг хувилбар бол үйлчилгээний гэрээ юм. Энэ тохиолдолд засгийн газар ашиглах эрхийг төрийн өмчит компаниудад олгож, харин тэдгээр нь гуравдагч этгээдээс үйлчилгээ авахаар гэрээ байгуулж болно. Бас эдгээр тогтолцоог хольж хэрэглэж болдог.

Гэрээний хэлбэр, нэр томъёо янз бүр байж болох ч энэ бүх тогтолцоог ашиг болон бүтээгдэхүүнд суурилсан хэсэгтэй бөгөөд ойролцоо өгөөжтэй байхаар төлөвлөж болдог. Тиймээс төр засгийн зорилт бол өөрийн хөгжлийн стратегид нийцүүлэн, мөн иргэдийн хүртэх үнэ цэнийг аль болох их байлгахад чиглүүлэн төр ба хөрөнгө оруулагч хоёр эрсдэлийг хуваалцах, орлогын хугацаа зохимжтой байх нөхцөлийг хангах явдал юм.

## Нөөц ашигласны төлбөр ногдуулах

Роялти буюу нөөц ашигласны төлбөр эсхүл түүний бүтээгдэхүүн хуваах хувилбар нь үйлдвэрлэл явуулж эхэлмэгц засгийн газрын орлогын урсгалыг төдийгүй улс орон баялгийнхаа төлөө наад захын төлбөр авах, мөн олборлолтоос үүдсэн нийгмийн өртгийг нөхөх явдлыг баталгаатай болгодог. Аливаа төсөл эдгээр өртөг зардлыг нөхөх хэмжээний роялтийг тогтвортой төлж чадахгүй бол нөхөн сэргэхгүй баялгаа ашиглуулсны хариуд ямар нэгэн төлбөр авах баталгаагүй болох тул улс орны хувьд сайн төсөл байх магадлал тун бага юм.

Нөөц ашигласны төлбөр нь бүтээгдэхүүний гарцыг сайн хэмжих, цаг хугацааны хуваарийг нарийвчлах, зах зээлийн үнэлгээг зөв тооцохыг шаарддаг. Үйлдвэрлэлийн зардлыг хасаж тооцдог нөөц ашигласны төлбөр нь ашгийн татварыг өөрөөр нэрлэж буйтай дүйцнэ. Зах зээлийн үнэлгээг тооцоходоо уурхайн амны цэвэр үнийг “буцаан тооцох” уламжлалт аргаас илүүтэйгээр нөөц ашигласны төлбөрийг олон улсын буюу олон нийтэд зарлагддаг үнэтэй аль болох уялдуулах нь маш дөхөм байдаг.

## Орлогод болон өндөр ашигт татвар хэрхэн ногдуулахыг анхаарах

Төлбөрийн өөр нэг хэлбэр бол орлогод ногдуулах татвар (“ашгийн татвар”) юм. Татвар ба нөөц ашигласны төлбөр хосолсон тогтолцоонд энэ нь гол төлөв нийтлэг үйлчилдэг компанийн орлогын татвар буюу хувьцаа эзэмшигчдэд очих өгөөжид ногдуулдаг татвар хэлбэртэй байдаг. Үүнийг

салбарын онцлогийг харгалзан, мөн буруу зөрүү үйлдлийг багасгахын тулд өөрчлөх нь элбэг. Заримдаа татварын хувь хэмжээг өндөр тогтоодог нь өндөр ашгаас татвар авах зорилготой. Засгийн газар бүтээгдэхүүн хуваах загварыг хэрэглэх бол татвар ба нөөц ашигласны төлбөр хосолсон тогтолцоотой ижил үр дүнд хүрэх боломжтой. Ингэхийн тулд “ашигт тос” эсхүл “ашигт байгалийн хий” болон өртгийг нөхөх хувь хэмжээ (“өртөгт тос” эсхүл “өртөгт байгалийн хий”)-ний зохих харьцааг сонгох замаар засгийн газарт ногдох хувь хэмжээг тэнцүүлж болно.

Ашгийн татвар нь эрсдэлийг засгийн газар, хөрөнгө оруулагчид хуваалцан үүрэхэд хүргэдэг бөгөөд өндөр ашигтай төслийн ашгаас засгийн газрын хүртэх хувь дагаж нэмэгдэж, харин алдагдалтай буюу ашиг багатай үед хөрөнгө оруулагчдын хувьд тодорхой хэмжээний хамгаалалт болж өгдөг.

Нөөц ашигласны төлбөрийг бодвол ашгийн болон түүнтэй төстэй татвар нь өртөг зардлыг тооцох шаардлагыг үүсгэдэг. Компаниудын тайлагнасан зардал нь хоорондоо хамааралтай талуудын бараа, ажил үйлчилгээний хэлцлийн дүнд гарсан байж болох тул гуйвуулсан байх эрсдэл элбэг тохиолддог. Түүнчлэн санхүүжилтийн хэлбэр нь засгийн газрын хүртэх өгөөжид нөлөөлдөг бөгөөд санхүүжилтийг зээлээр түлхүү хийвэл орлого буурахад хүргэдэг. Тиймээс нягт нямбай аудит, хяналтгүй, сайн боловсруулсан дүрэм журамгүй бол ашгийн татвараас авах орлогоо засгийн газар хурааж чадах магадлал эрс буурдаг. Цаашилбал их хэмжээний урьдчилсан хөрөнгө оруулалтыг шаарддаг олборлох үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан тус зардлын хэмжээгээр шууд хасалт хийх болон түргэвчилсэн байдлаар элэгдэл байгуулах бол татвар ногдох орлогын хэмжээ үлэмж буурдаг бөгөөд тус алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцсоноор орлогын татварын авах хугацааг ихээхэн хойшлуулдаг.

Өндөр үнэлгээтэй төслийн хувьд ашгийн үлэмжхэн хэсэг нь рент буюу өндөр ашиг байж болно. Энэ тохиолдолд төр засгаас өндөр ашгийн нэмэлт татвар, эсхүл мөнгөн урсгалаас тооцох

нэмэлт төлбөрийг ногдуулах замаар орлогын энгийн татвартай харьцуулахад тус ашгаас илүү их хувийг төр засагт шилжүүлэх боломжтой. Бүтээгдэхүүн хуваах тогтолцооны хувьд ч төслийн ашигт ажиллагааны ерөнхий түвшний ямар нэгэн хэмжээ тогтоож ашигт тосны засгийн газарт ногдох хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар адил үр дүнд хүрч болно.

Татварын аль ч тогтолцооны хувьд төр засаг тусгайлсан төлбөрийг нэмэлт байдлаар авах боломжтой. Тухайлбал, лицензийг уралдаант шалгаруулалтаар олгох явцад татварын бусад нөхцөлийг өөрчлөхгүйгээр гагцхүү урьдчилгаа урамшууллын төлбөрийг шалгаруулалтын нэг нөхцөл болгож болох юм.

### Татварын урамшуулал үзүүлэхээс зайлсхийж, татварын дэглэмээ хялбаршуулах

Илрэх боломжтой буюу шинээр илэрсэн баялагтай улс орны төр засгаас хөрөнгө оруулагчид тусгай урамшуулал олгохыг, тухайлбал татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, хөрөнгө оруулалтын зардлыг түргэвчилсэн байдлаар нөхөх, эсхүл нөөц ашигласны төлбөр, ашгийн татварын хувь хэмжээг бууруулахыг хүсэх нь элбэг тохиолддог. Төр засгийн зүгээс ийм урамшуулал олгохоос зайлсхийх нь зүйтэй. Хэрвээ нөөц ашигласны төлбөр буюу хувь эзэмшигчдийн оруулсан хөрөнгөнд ногдуулаг ердийн татварыг төлж чадахгүй юм бол тухайн хөрөнгө оруулалт нь улс орны хувьд сайн хэлцэл байх магадлал багатай. Эрдсийн бүтээгдэхүүний үнэ өсөх эсхүл шинэ технологи гарах зэргээр нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр өмнө нь эдийн засгийн хувьд ашиггүй гэж тооцогдож байсан төсөл төр засгийн ямар нэгэн татаас дэмжлэггүйгээр ашиглах боломжтой болох нь элбэг. Бүх баялгаа нэг дор ашиглах шаардлагагүй, бас зарим нэг баялгийг ашиглах нөхцөл хэзээ ч бүрэлдэхгүй байж болно.

Харин татварын үндсэн хэсэг болох нөөц ашигласны төлбөр, ашгийн татвар болон өндөр ашгаас авах ямар нэгэн хэлбэрийн татвар

гурав үйлчилж байгаа бол заримдаа бусад төлбөрүүдийг хялбарчлах буюу цуцлах нь төр засгийн хувьд ашигтай байж болно. Нэмүү өртгийн татвар (НӨТ)-ыг зориулалтаар нь буюу хөрөнгө оруулалтад бус бараа бүтээгдэхүүний дотоодын хэрэглээнд ногдох татвар хэлбэрээр ашиглах ёстой. Тухайлбал, олборлох компаниуд гадаадад экспортлох бүтээгдэхүүндээ НӨТ төлөх ёсгүй. Түүнчлэн импортын татварыг хөрөнгө оруулалтыг үргээхүйц хэмжээнд тогтоож болохгүй. Ийм төрлийн татвар, эсхүл орцод ногдуулах тогтмол хэмжээтэй хүү төлбөрт хэт их түшиглэсэн татварын тогтолцоо нь үр ашиггүй, эртхэн шиг их орлого авах хүсэл эрмэлзэлд хөтлөгдсөнөөс болж таамаглаагүй сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй. Түүнчлэн төр засгийн байгууллагууд татварын олон улсын тогтолцоонд анхаарлаа хандуулснаар суурин биш компаниуд баялгийн ашиглалтаас олсон орлогод ногдох татвараас зайлсхийх явдлыг таслан зогсоох хэрэгтэй. Засгийн газар нь байнга оршин суугч бус этгээдэд хийх төлбөр, тухайлбал ногдол ашиг, хүү, үйлчилгээний шимтгэл, эрхийн төлбөр зэрэгт суутган татварыг оновчтой бөгөөд аль болох жигд хувь хэмжээгээр ногдуулах шаардлагатай. Гадаадын хуулийн этгээдээс орлогын татвар хураах сайн арга механизм бүрэлдээгүй нөхцөлд эзэн улс орны хувьд нутаг дэвсгэрт нь олборлолт хийж олсон ашгаас хүртэх найдвартай арга бол суутган татвар байдаг. Татварын олон улсын гэрээ хэлэлцээрээр суурин биш этгээдэд ногдуулах суутган болон бусад татварыг хязгаарласан байж болох тул төрийн зүгээс хүчин төгөлдөр гэрээнүүдээ анхааралтай нягталж, хэлэлцэж буй гэрээгээр ийм үүрэг хүлээхээс зайлсхийх буюу хязгаарлах шаардлагатай.

Эзэн улсын баялагтай холбоотой эрхийг борлуулснаас олсон ашигт үнэ цэнэ өссөний татвар ногдуулах нь сүүлийн үед анхаарал татсан улс төр, эдийн засгийн чухал асуудал юм. Ялангуяа гадаад дахь толгой компанийн түвшинд хийгдсэн хэлцлийн дүнд эрх шилжиж байгаа тохиолдолд өссөн үнэ цэнээс татвар авахын тулд татварын хууль тогтоомж, тайлагнах шаардлагуудыг анхааралтай бүрдүүлэхээс

гадна тэрхүү үнэ цэнийг өсгөхөд нөлөөлсөн төлбөрүүдийг дараа нь татварын зорилгоор хэрхэн авч үзэхийг шийдвэрлэх шаардлагатай.

## Төр өгөөжөө нэмэгдүүлэхийн тулд хувь эзэмшигч болохоос зайлсхийх

Төр татварын дэглэмээр дамжуулан баялгаасаа өгөөж хүртдэг хэдий ч төслүүдэд нэмэлт хувь эзэмших явдал элбэг байдаг бөгөөд энэ эзэмшлийн хэлбэрээс хамааран хувьцаанд хөрөнгө оруулснаар санхүүгийн нэмэлт дарамт үүрэхэд хүрч болно. Магадгүй өөр зорилгоор хувь эзэмших талаар төр авч үзэх боломжтой. Үүнд хоёр дахь сайн арга бол өндөр ашгаас хувь хүртэх (ялангуяа мэдээллийн тэгш бус байдал ноцтой, хяналт тавих боломж хязгаарлагдмал үед), мөн улсын активыг хөрөнгө оруулалтад байршуулах (гэхдээ энэ нь эдийн засгийг олон тулгуурт болгох зорилготой зөрчилдөнө), компанийн шийдвэр гаргахад нөлөөлөх (гэхдээ зохицуулах эрхээрээ дамжуулж хийвэл илүү), эсхүл бизнес явуулах мэдлэгийг шилжүүлэх зэрэг аргууд хамаарна. *{Үндэсний баялгийн компаниудын талаарх Дүрэм 6-г мөн үзнэ үү.}*

## Ил тод, тогтвортой, найдвартай байдлыг бий болгох

Ил тод, жигд үйлчлэх дүрэм журам нь хөрөнгө оруулагчдад баталгаа болж, авилгын эрсдэлийг багасгаад зогсохгүй зарим хөрөнгө оруулагч тусгай нөхцөл шаардах явдлыг хязгаарлах боломжтой. Жигд үйлчлэх нь хэрэгжүүлэлтийг хөнгөвчилдөг. Жигд гэдэг нь одоо хэрэгжиж байгаа төслүүдэд үйлчилж буй дүрэм, гэрээний зүйл шинэ төслүүдэд адилхан үйлчлэх ёстой, эсхүл төр засгийн зүгээс татварын хувь хэмжээг өөрчлөх эрхээ хуучин төслүүд дээр ч хязгаарлана гэсэн үг биш юм. Улс орнууд аж ахуйн нэгжийн болон хүн амын орлогын татварын хувь хэмжээг үе үе өөрчилж байдаг. Мөн орд газруудын тооцсон үнэ цэнэ янз бүр байх ба дуудлага худалдаа нь эдгээрийн зөрүүгийн тодорхой хэсгийг орлого хэлбэрээр авах боломжийг засгийн газарт олгож байдаг. Татварыг жигд ногдуулах нь үндэсний өмчит баялгийн компаниудад ч хамаатай буюу

тэдэнд хувийн компаниудтай адил татварын нөхцөл үйлчлэх ёстой.

Хөрөнгө оруулагчид тогтвортой байдлыг гэрээгээр баталгаажуулахыг эрэлхийлж болно. Олон улс орон ийм гэрээний баталгааг гаргаж өгдөггүй, гэхдээ ингэх шаардлага үүсвэл засгийн газар тогтвортой байдлын хамрах асуудлыг хязгаарлах замаар хөдөлмөр эрхлэлт, эрүүл ахуйн аюулгүй байдал, байгаль орчин, аюулгүй байдал, хүний эрх зэрэг бусад чиглэлээр чөлөөтэй зохицуулалт хийх боломжоо хадгалж үлддэг. Цаашилбал нэг талаас компаниуд үйл ажиллагаагаа зогсоохоор далайлган нэмэлт хөнгөлөлт шаардах, нөгөө талаас төсөл өндөр үр ашигтай болоход засгийн газар хүртэх үр ашгаа нэмэгдүүлж чадахгүй байх гэсэн тэнцвэргүй нөхцөл байдал үүсэхээс төр засаг сэргийлэх ёстой. *{Дүрэм 1-ээс хууль эрх зүйн тогтолцоо, Дүрэм 2-оос ил тод байдлын тухай нэмж үзнэ үү.}*

## Татварын удирдлагын чадавхийг баталгаажуулж, татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх дүрэм журмыг хэрэгжүүлэх

Аливаа засгийн газарт татварын удирдлагын сорилтууд тулгардаг. Эдгээрийн зарим нь татвараас зайлсхийх зүй бус үйлдлийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шаардагдах хангалттай бүрэн эрхийг татварын байгууллагад олгоогүй, тааруухан бүрдүүлсэн тогтолцооны үр дүн байдаг. Татвараас зайлсхийх нийтлэг учир шалтгааныг шийдвэрлэх татварын дүрэм журмыг хэрэгжүүлэх нь чухал. Ийм дүрэм журмаар татварын объектийг тусгаарлан зааглах болон холбоотой этгээд хоорондын зарим төлбөрийг, жишээлбэл удирдлагын төлбөр, хүүгийн хэт өндөр зардал, эрсдэлийн хамгаалалтын зардал зэргийг татвар ногдох орлогоос хасахыг хязгаарлаж болно. Гэхдээ асуудлын нэг хэсэг нь зохион байгуулалтын шинжтэй бол нөгөө хэсэг нь ерөнхий чадавхи сул байдагтай холбоотой. Гэрээ байгуулах хэлэлцээний үр дүнд татварын тусгай зохицуулалтыг бий болгох нь татварын байгууллага болон хэлэлцээ

хийгчдэд аль алинд нь нэмэлт дарамт учруулж болно. Мэдээлэл, тайлан бүртгэлийн нэгдсэн системтэй байх, нөөц ашигласны төлбөр, бусад татвар, бүтээгдэхүүний ногдол хувийн орлогыг хураах чиг үүргийг төвлөрүүлэх, компаниуд төлбөрөө ил тод, төвлөрсөн нэг дансанд төлөхийг шаардах, орлого цуглуулахыг биетээр хийх мониторингтой нэгтгэх, бүтээгдэхүүнээр төлбөр хийх явдлыг арилгах нь татварын байгууллагад

тусална. Засгийн газар дотоодын зарим нэг чадавхи дутагдсан нийтлэг асуудлаар гадаадын мэргэжилтнүүдийг ашиглаж болох юм. Жишээ нь нийцлийг хангах, хураалтыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор олон улсын санхүү нягтлан бодох бүртгэлийн байгууллагыг гэрээлж болох юм.  
*{Мөн Дүрэм 3-аас гэрээний хэлэлцээ хийх болон эрх олголтын талаар үзнэ үү.}*

## ДҮРЭМ 5

Төр засаг нь олборлох төслүүд орон нутагт үр өгөөжтэй байх боломжуудыг эрэлхийлж, байгаль орчин, нийгмийн өртгийг тооцож, бууруулж, нөхөх ёстой.

Баялгийн төслүүд нь байгаль орчин болон нийгмийн өндөр өртгийг дагуулдаг бөгөөд сөрөг нөлөөг төслийн ойр орчимд байгаа хүмүүс илүүтэйгээр үүрэх нь бий. Гэхдээ ялангуяа үйл ажиллагаа үргэлжилж байх хугацаанд ажил олгох болон бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт хэрэгцээг бий болгох зэргээр орон нутгийн иргэдэд тодорхой үр ашгийг авчрах боломжтой.

Баялгийн менежмент нь үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нөлөөлөлд өртсөн иргэдэд учирч байгаа дарамт, өртгийг бууруулахад чиглэгддэг. Хэрвээ энэ боломжгүй бол дүйцэхүйц хэмжээний нөхөн төлбөрийг олгох асуудлыг төр засаг зохицуулах шаардлагатай. Ингэхдээ олборлолтын сөрөг нөлөөнд хамгийн ихээр автаж буй иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд нөхөн төлбөр чиглэсэн байх ерөнхий зарчмыг баримтлах шаардлагатай.

### Шийдвэр гаргах болон үнэлгээ хийхэд орон нутгийн иргэдийг оролцуулах

Нутгийн иргэд, орон нутгийн захиргаа болон нийт ард иргэд төслийг хэрэгжүүлэхийн өмнөх үе шатнаас үйл явцад оролцох шаардлагатай. Үндэсний нөөц баялгийн талаарх ерөнхий алсын хараанд нийцсэн шийдвэрүүдийг олон нийтэд мэдээлж, тэднийг оролцуулж байгаа талаар хараат бус судлаачдад бодитойгоор танилцуулах ёстой. Нутгийн иргэдийг оролцуулснаар тэд ямар нөлөөлөлтэй тулгарах талаар ойлгох, гарах өөрчлөлтүүдийг төлөвлөх, нөлөөллийг бууруулах, сайжруулах стратегийг боловсруулахад нутаг орны талаарх мэдлэгээ нэмэрлэх боломжийг олгож байдаг. Үүнийг хийхгүй бол сөрөг хандлага, цаашилбал зөрчилдөөн үүсэх эрсдэлтэй.

Гэхдээ нутгийн хүн амын болон нийт улс орны ашиг сонирхол зөрүүтэй байх боломжтойг хүлээн зөвшөөрөх нь чухал. Орон нутгийн тодорхой бүлгүүдэд таагүй хэдий ч улс оронд ихээхэн үр өгөөжтэй шийдвэрийг гаргах тохиолдолд төр засгаас эдгээр бүлгүүдэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. *{Дүрэм 1-ээс олборлолт хийх шийдвэрийг улсын стратегийн хүрээнд гаргах тухай үзнэ үү.}*

### Өмчлөлийн эрхийг тогтоож, тодорхойлох

Засгийн газар нь орон нутгийн болон үндэсний хэмжээнд иргэдтэй тохиролцсоны үндсэн дээр газрын хэвлийн нөөц, баялгийг өмчлөх эрхийг нарийвчлан тодорхойлж, цаашдын орлогыг захиран зарцуулах эрхийг хуваарилах шаардлагатай. Үргэлж биш хэдий ч ихэнхдээ газрын хэвлийн баялгийг ард түмний нэрийн өмнөөс төр өмчилдөг бол олборлолтын нөлөөнд өртөх газар, ус, байгалийн бусад баялгийг нутгийн олон нийт өмчилдөг, эсхүл наад зах нь тус баялгаас хамаарч байдаг. Үүнд тухайн төслийн ойролцоо амьдардаггүй ч гол ус, эргийн орчим зэрэг нөлөөнд автаж буй байгаль орчноос хамааралтай хүмүүсийг хамаатуулж ойлгоно. Нөлөөнд өртсөн газар нутагт хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн засаж залруулах зохих арга хэмжээг төр засгийн зүгээс шуурхай, итгэл төрүүлэхүйц бөгөөд ил тодоор авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Төр засаг зохистой нөхөн төлбөр хийхгүй, улс орны үр өгөөжөөс тэгш хүртээхгүй бол иргэдийн бухимдлыг төрүүлэх, олборлолтын төслүүд саатах, цаашилбал зөрчил тэмцэлд ч хүргэх эрсдэлтэй. Түүнчлэн нөлөөнд өртсөн



нутгийн эмзэг бүлгийн иргэдэд ирээдүйд нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлэх шаардлага үүссэнээр төсвийн зардлыг нэмэгдүүлж болно. Гэхдээ нутгийн уугуул иргэд болон урьд өмнө нь орхигдсон газар нутагт үндэсний онцлогоос хамааран тусгайлан үүрэг хүлээнээс бусад тохиолдолд төсвийн орлогын илүү их (сөрөг нөлөөнд олгох нөхвөрөөс давсан) хувь хэмжээг бусадтай харьцуулахад баялаг ихтэй бүс нутагт олгох явдлаас төр засаг зайлсхийх хэрэгтэй. *{Дүрэм 7-гоос орлогын хуваарилалтын хэсгийг мөн үзнэ үү.}*

### Олборлолтын сөрөг нөлөөг хэмжих ба бууруулах

Улс орон олборлолтоос сайн ашиг хүртэхийг баталгаажуулахын тулд төр засаг ашиглалтын тусгайлсан зөвшөөрлийг олгохоос өмнө болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлсон байх хэрэгтэй. Зарим тохиолдолд засаглал эсхүл технологи сайжрах хүртэл, эсхүл гарах үр нөлөөг сайтар үнэлэх боломжтой болтол үйл ажиллагааг хойшлуулах нь зохистой байж болно. *{Дүрэм 1-ээс шийдвэр гаргахад олон нийт оролцох тухай болон Дүрэм 3-аас эрх үүргийг хуваарилах тухай хэсгүүдийг мөн үзнэ үү.}*

Хэрвээ засгийн газар эрхийг нь олгосон бол олборлолтын сөрөг үр нөлөөг бууруулах талаар төлөвлөх ёстой. Тухайлбал, онцгой байдал үүсэхэд хэрэгжүүлэх хувилбарт төлөвлөгөөг танилцуулж, батлуулахыг компаниудаас шаардах хэрэгтэй. Үүсч болох нөхцөл байдлыг урьдчилан тооцохдоо жишээ нь газрын тос асгарах зэрэг осол гарлаа гэхэд түүнийг арилгах техник болон мэдлэг туршлагын бэлэн байдалд анхаарна. Үүний сацуу тухайн төлөвлөгөөг бүх талууд дагаж мөрдөх, ирээдүйд гарч болох төслийн төлөвлөөгүй үр нөлөөг тодорхойлох зорилгоор төсөл хэрэгжих бүхий л үе шатанд хяналт тавих бололцоо бүрдсэн байх ёстой. Болзошгүй өртөг зардлыг бүгдийг урьдчилан таамаглах боломжгүй тул байгаль орчин, нийгмийн нөлөөг тогтмол хянах, удирдан зохицуулах тогтолцоог бүрэлдүүлэхийг хэрэгжүүлэгч компаниас шаардах

нь төслийн төлөвлөлтийн шатанд үнэлгээ хийхийн нэгэн адил чухал юм.

Төр засаг нь байгаль орчны стандартыг (ялангуяа Экваторын зарчмууд зэрэг олон улсын стандартуудад нийцүүлэн) тогтоох болон мөрдүүлэх үүрэгтэй бол олборлолтын компаниуд ихэнх тохиолдолд байгаль орчинд учрах хохирлыг бууруулах илүү боломжтой. Төр засгаас тухайн гэрээ лицензийг олгохдоо торгууль шийтгэлийг тусгаагүй бол компаниуд үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны үр дагаврыг авч үзэх сонирхол багатай байдаг. Төсөл ашиггүй болбол албан ёсоор хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн өдрөөс аль эрт компани төслийг орхих буюу гуравдагч этгээдэд худалдах тохиолдол гардаг тул төр засаг өөрөө эсхүл тухайн компани нөхвөр арга хэмжээнд зориулсан тусгайлсан сан үүсгэх шаардлагыг хангах ёстой. Хараат бус талуудыг өрсөлдөөний үндсэн дээр шалгаруулсан гэрээт байгууллагыг хөлсөлж нөхөн сэргээх гэх мэт байгаль орчны ажлуудыг гүйцэтгүүлж болно.

Төслийн эргэн тойрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд, тухайлбал хувийн болон төрийн хамгаалалтын албад хүч хэтрүүлэн хэрэглэх тохиолдолд хүний эрхийн асуудал үүсдэг. Иймд хүний эрхийн зөрчил гарсан үед шийдвэрлэх эрх зүйн сайн механизмыг төслийн үйл ажиллагаанд багтаах ёстой.

Гар аргаар ашигт малтмал олборлох нь эрүүл мэнд, аюулгүй байдал болон орон нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөрөө муу нэртэй байдаг. Гэхдээ энэхүү албан бус салбар нь ядуу амьдралтай хүмүүсийн орлогын эх үүсвэр нь болж байдаг. Төр засгаас тус салбарыг албан болгох, хяналт тавих, сөрөг талыг нь багасгахыг зорихын сацуу ядуурлыг бууруулах дэмжлэгийг хадгалах буюу сайжруулах хэрэгтэй. Ингэхдээ хоршоолол гэх мэт олон нийтийн оролцоонд суурилсан шийдлийг ашиглахаас гадна ядуурлыг бууруулах өргөн боломжуудыг бий болгохын тулд эдийн засгийг нийтэд нь олон тулгуурт болгон төрөлжүүлэхийг дэмжих хэрэгтэй.

Эцэст нь, асуудлуудыг ерөнхийд нь шийдвэрлэхэд эмзэг, цөөнх бүлгүүдийн асуудал орхигдох нь элбэг тохиолддог тул баялгийн олборлолтын эдгээр бүлгүүдэд үзүүлэх нийгмийн нөлөөг нарийвчлан тогтоож, шийдвэр гаргах үйл явцад харгалзах шаардлагатай.

### Орон нутаг олборлолтоос хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг ашиглах

Олборлох төслүүд нь ойр орчмын нутгийн иргэдэд эдийн засаг болон нийгмийн томоохон боломжуудыг нээж өгдөг. Хайгуул хийхийг зөвшөөрөх, компанийн бүтээн байгуулалтын төлөвлөгөөг батлахдаа эрх бүхий байгууллагууд өртөг зардлын хамт дээрх боломжуудыг тооцон үзэх ёстой. *{Дүрэм 10-аас олборлох салбарт ханган нийлүүлэлт хийх боломжтой бизнес, ажиллах хүчийг нийт эдийн засгийн хувьд хөгжүүлэх тухай мөн үзнэ үү.}*

Уул уурхайн төслүүд нь ялангуяа орон нутгийн ажиллагсад сургалтад хамрагдах болон шууд ажлын байраар хангагдах боломжийг бүрдүүлдэг. Орон нутгийн ажиллах хүчний чадвар төсөлд шууд оролцоход хангалтгүй байсан ч олборлох салбарын ажиллагсдын зүгээс орон нутгаас бараа үйлчилгээ авах хэрэгцээ, нэн ялангуяа нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний салбаруудад үүсэх магадлал ихтэй. Орон нутгийн хүчин чармайлт ба тэдний үйлчилгээг олборлох компаниуд авахыг төр засаг хөхиүлэн дэмжих ёстой.

Олборлолтын төслүүд томоохон хэмжээний дэд бүтцийг шаардаж болох бөгөөд тэр нь тухайн

бүс нутагтаа ихээхэн өгөөжтэй байх боломжтой. Энэхүү үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд төр засаг компаниудтай хэлэлцэн тохирох замаар дэд бүтцийг бусад хэрэглэгчид нээлттэй ашиглах асуудлыг авч үзэх шаардлагатай. Гэхдээ үүнийг дэд бүтцийг төлөвлөх шатанд хувийн хэвшлийн оролцоотойгоор шийдвэрлэх нь чухал юм. *{Дүрэм 9-өөс дэд бүтцийн хөгжүүлэлтийн талаар мөн үзнэ үү.}*

### Нутгийн удирдлагатай харилцах, тэдний чадавхийг бэхжүүлэх

Нутгийн удирдлагын байгууллагууд нь олборлох салбарын нөлөөллийг удирдан зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нутгийн удирдлага сул байвал үйлчилгээ үзүүлэх, мөн олборлолтын төслүүдийн сөрөг нөлөөг бууруулахад саад учруулна. Хэрвээ нутгийн удирдлага иргэддээ муу үйлчилж байвал энэ нь зөрчил үүсгэж олборлолтын төслүүдэд аюул учруулж болно.

Нутгийн удирдлагын байгууллагын чадавхийг дээшлүүлэх нь компаниудын (мөн хандивлагчид болон иргэний нийгмийн) хувьд орон нутгийн иргэдтэй харилцаагаа бэхжүүлэх, тэдний ирээдүйгээ хэрхэн харж буйг ойлгох, алсын хараанд нь нийцсэн төслүүдийг хэрэгжүүлэхэд туслах арга зам юм. Чадавхи нь онцгой сул байвал богино болон дунд хугацааны үйлчилгээг компанийн зүгээс үзүүлэх нь зохистой байж болно. *{Дүрэм 1-ээс нутгийн удирдлагын байгууллага болон бусад төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг хуваарилах тухай, мөн Дүрэм 7, 8-аас баялгийн орлогын нутгийн удирдлагын байгууллагад үзүүлэх нөлөөллийн талаар үзнэ үү.}*

## ДҮРЭМ 6

Үндэсний компаниуд нь хариуцан тайлагнадаг бөгөөд нягталж тодорхойлсон эрх үүрэгтэй, арилжааны хувьд үр ашигтай байх ёстой.

Үндэсний өмчлөл бүхий олборлолтын компаниудыг байгуулах нь газрын хэвлийн баялгийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах боломжийг ашиглах улс орны стратегийн нэг гол хэсэг байж болох юм. Ийм компанийг байгуулах сонирхлыг өдөөгч хэд хэдэн шалтгаан бий. Үүнд хувийн компаниудаас авдаг татвар хангалтгүй гэж үзсэн тохиолдолд өндөр ашгийг төрд авч үлдэх, дотоодын компаниудад технологи, бизнесийн туршлагыг шилжүүлэн авахыг хялбарчлах, дотооддоо олборлох болон үйлдвэрлэлийн бусад салбарын хэлхээ холбоог хөгжүүлэхийг дэмжих гэх мэт үйл ажиллагааны шийдвэрт нөлөөлөх зэрэг хамаарна. Эдгээр зорилтууд заавал нэгэн зэрэг биш ч гэсэн улс орны янз бүрийн нөхцөл байдалд тохирч болох учраас аль нэгийг сонгоход хүргэж болно. Түүнчлэн олборлох салбар болон төр засгийн институци хөгжихийн хэрээр үндэсний баялгийн компаниудын гүйцэтгэвэл зохих үүрэг өөрчлөгдөж болно.

Эдгээр боломжийг авчирдаг хэдий ч тохиромжгүй үүргийг ногдуулж, тааруу удирдах тохиолдолд үндэсний компаниуд улс орны хувьд эрсдэл дагуулж болно. Байдал даамжирвал эдгээр компаниуд иргэдэд үнэ цэнэ бий болгож өгөх бус түүнийг үгүй хийхэд хүргэсэн үзэгдлийн түүхэн жишээ олон юм.

### Үндэсний компанийн үйл ажиллагааны үүргийг тогтоох

Улс өөрөө хангалттай чадавхтай хийгээд сайн засаглалтай бол эдгээр үйл ажиллагааны үүргийг (тухайлбал хайгуул, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийг бие дааж болон бусадтай хувь нийлүүлэн түншилж явуулах гэх мэт) гүйцэтгүүлэх үндэсний компани байгуулах нь ашигтай байж болно. Харин дээрх хоёр хүчин зүйл хангалтгүй байвал

үр ашиггүй байдал, гүйцэтгэх удирдлагын хувийн сонирхлын улмаас төр засагт орох орлогыг багасгах, бүр үгүй хийх ч боломжтой. Цаашлаад үндэсний компанид төрийн хөрөнгийг оруулснаар эдийн засгийг олон тулгууртай болгох зэрэг үндэсний бусад зорилтыг хэрэгжүүлэх боломж алдагдах өртөг дагалддаг. *{Дүрэм 1-ээс дүрэм журам, институцийн бүтцийг бүрдүүлэх талаар мөн үзнэ үү.}*

Үндэсний компани тодорхой үүргийнхээ хүрээнд эрсдэл хүлээх хангалттай хөрөнгө, мэдлэг туршлагагүй бол шийдвэр гаргагчдын зүгээс хувь нийлүүлэгчид болон өрсөлдөөний шахалтад байдаг гадаадын олборлогч компаниудыг авч үзэх хэрэгтэй. Төрийн зүгээс үндэсний чадавхийг бүрдүүлэхийг эрмэлзэж байгаа бол гадаадын компаниудтай хамтрах нь мэдлэг шилжүүлэн авах боломж олгоно.

Хувийн хэвшлийн оролцооны үр өгөөж нь төр хувийн компаниудын ашгаас зохистой хэмжээний татвар авах замаар тэдний үйлдлийг зохицуулах боломжтой байхад тулгуурладаг. Хэрэв ийм нөхцөл бүрдээгүй бол үндэсний компаниуд “салбарыг ойлгох цонх”-ны үүргийг гүйцэтгэх замаар төр засгийн мэдлэг туршлагыг нэмэгдүүлэхэд тустай байж болно. Үндэсний компани техникийн шинжтэй нарийн мэдлэг, мэдээллийг дамжуулж, төр засгийн дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх чадварыг бэхжүүлэх юм. *{Дүрэм 4-өөс татвар ногдуулах тухай мөн үзнэ үү.}*

Үндэсний компаниуд бас дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжиж чадна. Хувийн болон гадаадын олборлолтын компаниуд дотоодын эх үүсвэрээс худалдан авалт хийж, дотоодын нийгмийн эрэлт хэрэгцээг удирдах нь

эдийн засагт ашигтай хэдий ч тэдгээрийн үйл ажиллагааны шийдвэрүүд нь ашиг олох үндсэн сэдэл дээр тулгуурладаг учраас олборлолтоос улсад орох татварын бус өргөн цар хүрээтэй үр ашгийг (мөн өртгийг) үгүйсгэх хандлагатай байдаг. Уг асуудлыг зохицуулалтаар, тухайлбал хувийн компанийг дотоод ханган нийлүүлэлтийг дэмжихийг шаардах зэргээр шийдвэрлэж болно. Төр засгаас дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээ орон нутгийн чадварыг бэхжүүлэх замаар илүү өргөн хүрээний эдийн засгийн зорилтуудыг дэмжих чиглэлийг үндэсний компаниудад өгч болох хэдий ч ийм стратеги нь тэдний арилжааны үр ашгийг бууруулах боломжтой. Урт хугацаандаа төр засаг дотоодын ханган нийлүүлэгчдийг олон улсад өрсөлдөх чадвартай болоход нь дэмжлэг үзүүлж, тийм шаардлага тавих нь зүйтэй. Эс бөгөөс үр ашиг муутай байдал нь төр засгийн орлогыг бууруулна.

### Үндэсний компанийн засаглалын үүргийг авч үзэх

Төр засаг үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлохын зэрэгцээ татвар хураах, үйл ажиллагааны эрх олгох, хяналт тавих, кадастрын менежмент хийх зэрэг бодлого тодорхойлох болон зохицуулалтыг хэрэгжүүлэх засаглалын үүргийг тогтоож өгөх ёстой. *{Дүрэм 1-ээс төр засгийн байгууллагуудын үүргийг тодорхойлох хэсгийг мөн үзнэ үү.}*

Төр засаг эдгээр сонголтыг хийхдээ үүрэг тус бүрийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх болон хангалттай чадавхийг бүрдүүлэх хоёрын тэнцвэрийг харгалзан үзэх шаардлагатай. Төр засгийн чадавхи хангалттай бол үйл ажиллагааны чухал үүрэг бүхий үндэсний компанийг аливаа сонирхлын зөрчлөөс тусгаарлах үүднээс засаглалын үүргээс чөлөөлөх хэрэгтэй. Харин төр засгийн чадавхи хангалтгүй бол багахан нөөц, мэдлэг туршлагыг нэг байгууллагад төвлөрүүлэх нь зохимжтой байж болно. Гэхдээ гарч болох аливаа сонирхлын

зөрчлийг төрийн зүгээс тодорхойлж үндэсний компанийн зан байдалд зохих хяналтыг тавих нь зүйтэй. Ийм шийдэл богино хугацаанд илүү тохиромжтой бөгөөд үйл ажиллагаанд шууд оролцсоноор хуримтлагдах мэдлэг туршлагыг төрийн бусад байгууллагуудад чадавхи бий болгоход ашиглах ёстой. Эрх үүргийг нэгтгэсэн үндэсний байгууллагыг үүсгэх явцад тодорхой ашиг сонирхлын улмаас эрх мэдэл шилжихэд саад учрахаас сэргийлсэн “гарах төлөвлөгөө”-г суулгаж өгөх хэрэгтэй.

### Харилцан хяналтын тогтолцоог бүрдүүлэх

Үндэсний өмчит компани засаглал ба үйл ажиллагааны хосолсон үүрэг гүйцэтгэж буй тохиолдолд ашиг сонирхлын зайлшгүй үүсэх зөрчлийг шийдвэрлэхэд харилцан хяналтын тогтолцоо тусална. Ер нь компанийн удирдах зөвлөлийн гишүүд улс төрөөс хараат бус, мэргэжлийн мэдлэг боловсролыг шалгуур болгосон өрсөлдөөнт журмаар томилогдох ёстой. Зөвлөлд төр засгийг төлөөлөх гишүүдийн тоог сонгохдоо тэнцвэрт байдлыг харгалзах нь зүйтэй. Эдгээр төлөөлөл нэг талаас компани, засгийн газрын харилцааны үндсийг хангаж, үндэсний компанид эрх мэдэл хэт төвлөрөхөөс сэргийлэх боловч нөгөө талаас хяналтыг нухацтай хэрэгжүүлэхэд зориулах цаг хугацаа, мэргэжлийн мэдлэг чадвар дутсанаас компанийн шийдвэр гаргах үйл явцыг удаашруулах магадлалтай. *{Дүрэм 2-оос хариуцан тайлагналын тухай мөн үзнэ үү.}*

Үндэсний компани наанадаж хувийн компанийн дагаж мөрддөг ил тайлагнах стандартуудыг биелүүлэх ёстой. Үндэсний компани нь нийтэд зориулан бүртгэл тооцоог олон улсын стандартын дагуу бэлдэж, хөндлөнгийн аудит хийлгэх бөгөөд хувийн хэвшлийн өмчлөлтэй холбоотой ашиг сонирхол, түүнтэй холбоотой шилжүүлгийг ойлгомжтой байдлаар тодруулж байх ёстой. Ил тод байдлыг хангахад онцгой анхаарах асуудал бол үндэсний компани төрийн нэрийн өмнөөс

газрын тос худалдах явдал юм. Компанийн хүлээн авч буй газрын тосны хэмжээ, түүнийг борлуулсан тосны үнэ, чанар, хэмжээ, огноо зэргийг ил тайлагналд хамруулах ёстой.

Эцэст нь хууль тогтоогч эсхүл зохих хяналтын байгууллагын зүгээс үндэсний компанид байнгын, системтэй хяналтыг тавих хэрэгтэй. Зорилгодоо хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааг үр ашигтайгаар явуулах чөлөөт байдлыг үндэсний компанид олгох болон улс төрчид, төрийн албан хаагчид хөндлөнгөөс хэт оролцохоос сэргийлэх үүднээс хууль тогтоох эсхүл төрийн байгууллага нь үйл ажиллагааны асуудалд оролцохгүйгээр жилийн гүйцэтгэлийн тойм хэлэлцүүлэг зэрэг өндөр түвшний шийдвэр гаргалтыг хянах боломжтой.

## Гүйцэтгэх үүргийн хувьслыг зохицуулах

Шинэ сорилтууд тулгарах, компанийн чадавх нэмэгдэхтэй уялдан үндэсний компаниудын үүргийг дахин хуваарилж болно. Жишээлбэл, төрийн хувь эзэмшлийг хариуцсан холдинг компани байдлаар ажиллаж байгаад хувийн компанитай хамтарсан үйл ажиллагаа явуулж болно. Эцсийн дүндээ үндэсний компанийн төрийн өмнөөс гүйцэтгэх үүрэг нь үр ашигтай төрийн институциудыг бий болгох, хүчирхэг салбар болон үйл ажиллагааны чадварыг дэмжих зэрэг үр дүнд хүрэх хэрэгсэл байх явдлыг төр засаг баталгаажуулах хэрэгтэй. Ийм үйл явцын дараа үндэсний компани үйл ажиллагаагаа явуулах бол бизнесийн хувьд үр ашигтай байх ёстой.

# Орлогыг удирдах



## ДҮРЭМ 7

Төр засаг орлогыг одоо болон ирээдүй үеийнхний хувьд оновчтой бөгөөд тэгш үр нөлөөтэй байхаар хөрөнгө оруулахад зориулах ёстой.

Баялгийн олборлолтын орлогыг хэрхэн хуваарилахыг төр засаг шийдвэрлэх ёстой. Орлогыг улсын болон орон нутгийн төсөвт шууд хуваарилах, түүнийг татвар бууруулах эсхүл халамжийн төлбөр, татаас, “баялгийн ногдол ашиг” зэргийн төлбөрт шилжүүлэх, тэтгэврийн болон байгалийн баялгийн санд нэмэрлэх, зээлийн байгууллагуудын үйл ажиллагааг санхүүжүүлэх, эсхүл үндэсний компанид үлдээх буюу хуваарилах болон бусад боломжууд ч бий.

Эдгээрээс сонголт хийхдээ нийгэм доторх ба үе хоорондын тэгш байдлыг хангах болон хүн амын амьжиргааг дээд зэргээр сайжруулахад орлогыг үр ашигтай зарцуулах гэсэн хоёр гол зорилгыг төр засаг харгалзах нь зүйтэй.

Баялгийн орлогын мөн чанар нь асуудлыг дараах дөрвөн шалтгаанаар төвөгтэй болгодог. Нэгдүгээрт, нөхөн сэргэхгүй баялгийн олборлолт угаасаа тогтвортой үргэлжлэх боломжгүй. Эдийн засгийн үр ашигтай нөөц хорогдох, эсхүл наад зах нь орлогын урсгал хумигдах цагт улс төлөвлөгөөтэй байх ёстой. Байгалийн баялаг хомсодоход түүнтэй дүйцэхүйц буюу гол төлөв биет болон хүмүүний капитал баялгийг хуримтлуулах үйл ажиллагаа шаардагдана. Хоёрдугаарт, олборлох төслүүд бүрэн хүчин чадлаараа ажиллах үед баялгийн орлого асар ихээр өсдөг бол нөөц шавхагдах үед уг орлого урт хугацааны уналтад орох хандлагатай байдаг. Тиймээс нийт эдийн засагтай харьцуулахад их дүнтэй мөнгөний талаарх шийдвэрийг төр засаг цаг хугацааны ахархан мөчлөгт гаргах ёстой болдог. Өөрөөр хэлбэл, нэлээд хугацаанд төр засаг орлогынхоо зөвхөн зарим хэсгийг хэрэглэх буюу тодорхой хэлбэрийн хуримтлал бүрдүүлэх шаардлага үүснэ. Гуравдугаарт, түүхий эдийн үнэ,

мөн түүнээс хамааралтайгаар орлогын хэмжээ жилээс жилд өөрчлөгдөж байдаг. Энэ тохиолдолд богино хугацааны орлогын хэлбэлзэл нь засгийн газрын зардлын сөрөг уршигтай хэлбэлзэлд хүргэхээс сэргийлсэн бодлогын арга хэрэгсэл шаардлагатай. Дөрөвдүгээрт, эдийн засагт орж байгаа орлогын урсгал нь макро эдийн засгийн сөрөг үр дагавартай байх боломжтой. Эдийн засагт ихээхэн мөнгө урсан орохын хамтаар дотоодын бараа, үйлчилгээний эрэлт нэмэгдэж, экспортын боломж өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн бизнесийг доройтуулж болзошгүй бөгөөд уг үзэгдлийг “голланд өвчин” гэж нэрлэдэг. Хөрөнгө капиталын хуримтлал нэмэгдэх, ирээдүйн орлогын урсгалын талаарх хүлээлт ихсэх нь зээлийн хөөс, түүнтэй төстэй санхүүгийн бусад асуудлыг мөн дагуулж болно. Түүнчлэн дотоодын хөрөнгө оруулалт богино хугацаанд ихээр нэмэгдэхэд эдийн засгийн шингээх чадвар дутагдаж инфляци үүсэх боломжтой. Эцэст нь иргэд баялгийн олборлолтын орлого шударга хуваарилагдахгүй байна гэж үзвэл зөрчилдөөн ч үүсэж болзошгүй. *{Дүрэм 8-аас орлогын савалгаа, Дүрэм 9-өөс эдийн засгийн шингээх чадварыг нэмэгдүүлэх тухай мөн үзнэ үү.}*

### Ирээдүй үеийнхэнд зориулан тэгш хуваарилалт хийх явдлыг хангах

Эхний буюу тэгш байдлыг хөхиүлэн дэмжих зорилгод хүрэхийн тулд орлогын хичнээн хувь одоогийн иргэдэд үр өгөөжөө өгөх болон хэр ихийг ирээдүй үеийнхэнд хөрөнгө оруулах талаар төр засаг шийдэх хэрэгтэй. Энэ нь зарцуулах эсхүл хуримтлуулах боломжтой баялгийн орлогын талаарх бодитой тооцоонд тулгуурлахаас гадна улс орны өсөлтийн төлөвөөс хамаарна.

Өсөлт өндөр бол өнөөдрийн иргэд ирээдүй үеийнхэнтэй харьцуулбал хамаагүй ядуу байх тул одоогийн иргэдийн аж байдлыг сайжруулах зарим зарцуулалтыг хойшлуулахгүйгээр хийх хэрэгтэй. Гэхдээ зарцуулалт ихээр нэмэгдэхэд эдийн засаг шингээх чадвартай эсэхийг ийм шийдвэрийг гаргахдаа төр засаг дэнслэх шаардлагатай. Орлогын өсөлт доогуур байх төлөвтэй улс оронд одоо болон ирээдүй үеийнхний орлогын ялгаа бага байх магадлалтай. Ийм тохиолдолд тэгш байдлыг хангахын тулд төр засаг орлогын харьцангуй бага хувийг өнөөдөр зарцуулж, илүү хэсгийг хөрөнгө оруулалтад зориулах хэрэгтэй.

Цаг хугацааны хувьд илүү тэгш хуваарилалтыг хангахаас гадна төрийн зарцуулалт үр дүнтэйг харуулах, улмаар баялгийг удирдах төр засгийн урт хугацааны төлөвлөгөөнд нийтийн дэмжлэгийг авахын тулд орлогын зарим хэсгийг өнөөдөр зарцуулах нь чухал байж болно. Нөөц баялгийн эрин үе эхэлснээр нийтийн хүлээлт хэтэрхий ихсэх, мөн өрсөлдөгч сонирхлын бүлгүүд орлогоос хувь хүртэхийг шаардах аюулыг дагуулдаг. Ийм шаардлага, түүний дагуу хэт өндөр зардал гаргах явдлыг нээлттэй, оролцоог хангасан үндэсний хэмжээний төлөвлөлт болон бодит тоо баримтыг дэлгэснээр хязгаарлаж болно. Ядуу буурай орнуудад зарим хэрэглээг баталгаатай хангах шаардлагатай ч ихэнх тохиолдолд орлогыг байгаа хэмжээгээр нь хэрэглэх явдал улс төрийн аливаа тогтолцооны хандлага байдаг тул улс орнууд залуу болон ирээдүй үеийнхэн баялгийн үр өгөөжийг хүртэх эрхийг хамгаалах ёстой. *{Дүрэм 3-аас энэхүү хуримтлалын шийдвэрийг гаргахад баялгийн суурь бааз, баялгийн хорогдлын талаар зөв ойлгох, орлогын урсгалыг баталгаажуулахын ач холбогдлын талаар мөн үзнэ үү.}*

Төрөөс жил бүр зарцуулах болон хуримтлуулах мөнгөн дүнг төсвийн шууд дүрмээр тогтоох нь хуримтлал үүсгэх асуудлыг урт хугацаанд шийдвэрлэхэд хөтлөнө. Ийм дүрмээс няцах төр засгийн оролдлогоос сэргийлэх үүднээс тухайн дүрэм болон жил бүр хуримтлуулах ба зарцуулах мөнгөн дүнгийн мэдээлэл нээлттэй байх нь чухал. Төр засаг шийдвэрээсээ ухрахгүй байх явдлыг

хангахад иргэний нийгэм болон хараат бус эрх бүхий байгууллагуудын хатуу хяналтын хамт засаглалын энэхүү бүтэц тусална.

## Өнөөгийн иргэдийн тэгш байдалд анхаарах

Орлогыг хуваарилахдаа төр засаг өнөөгийн иргэдийн тэгш байдлыг анхаарах нь мөн чухал. Үүнд нийгмийн бүлэг, хүйс, орлогын түвшин зэрэг хүчин зүйлсийг бодолцон үр өгөөжийг тэгш хуваарилах явдалд хянуур хандах (болон хөндлөнгөөс оролцох) шаардлага үүсдэг.

Төр засгаас нэн ядуу болон харьцангуй ядуу иргэдийн амьжиргааг дэмжихэд баялгийн орлогыг ашиглахыг зорьж болно. Үүнийг төр засаг олон төрлийн сувгаар дамжуулан хийж болох бөгөөд гагцхүү илүү үр ашигтай байх эсхүл илүү олон зорилтот бүлгүүдэд хүрэх сувгуудын алиныг сонгохыг дэнслэх шаардлагатай.

Баялаг нь эдийн засгийн огцом өсөлтөд хүргэж болох хэдий ч олон тохиолдолд ядуу иргэдэд үр ашгаа өгч чаддаггүй. Замби улсын нэг хүнд ногдох ДНБ 2003-2010 онуудад 30 гаруй хувиар өссөн боловч хамгийн бага орлоготой 20 хувьд ногдох орлогын хувь 6.2-оос 3.6 болж буурсан байдаг.

*Дэлхийн Банкны хөгжлийн үзүүлэлтүүд-г ашиглан хийсэн тооцоо.*

Нэг удаагийн, ямар нэгэн болзолгүй шилжүүлэг нь чинээлэг хэсэгтэй харьцуулахад ядуучуудад илүү үр өгөөжтэй байх тул ядуурлын түвшин өндөр, зээл авахад хүндрэлтэй улс оронд ийм шууд шилжүүлэг нэлээд зохимжтой байж болно. Иргэдэд шууд бэлэн мөнгө шилжүүлэх нь өрхийн зарцуулалтад учрах саадыг арилгах, чадавхи дутагдах, хувийн зээл авахад саад учрахыг багасгах юм. Түүнчлэн орлогыг хэрхэн зарцуулж байгаад олон нийтийн анхаарлыг хандуулж, улмаар төр засгаас хариуцлага нэхэх эрмэлзлийг нэмэгдүүлнэ.



Гэхдээ энэ төрлийн шилжүүлэг амжилттай байх эсэх нь хөрөнгийг үр дүнтэй хуваарилж чадах төрийн захиргааны тогтолцооноос хамаарах бөгөөд үгүй бол хөрөнгө завших явдал гарч болзошгүй. Түүнчлэн, иргэд авсан мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийхгүй бол бэлэн мөнгөний шилжүүлэг нь баялгийн орлогыг хөрөнгө оруулалтад ашиглах төр засгийн бодлоготой зөрчилдөж, бас төрийн хэрэгжүүлэх төслүүдэд зарцуулах боломжтой хөрөнгийн хэмжээг бууруулах юм. Цаашилбал эдийн засгийн шингээх чадварт эрх баригчид онцгой анхаарах хэрэгтэй. Бэлэн мөнгөний шилжүүлгээс үүдсэн нэмэлт эрэлтийг бизнесүүд зохих түвшинд хариулж чадахгүй бол ийм шилжүүлэг нь дотоодын үнийн инфляци үүсгэх төдий үр нөлөөтэй байна.

Түгээмэл хэрэглэгддэг бөгөөд нийтээр мэддэг хэдий ч татаас нь ерөнхийдөө орлогыг хуваарилах хамгийн тохиромжгүй арга хэрэгсэл байдаг. Ялангуяа баялаг ихтэй улс орны иргэд эрхтэй гэж үзээд түлшний татаасыг шаардах явдал олон нийтийн зүгээс гарч болно. Гэвч татаас нь үрэлгэн хэрэглээг нэмэгдүүлэх, хууль бус хилийн наймааг өдөөх, зэрэгцээ зах зээл үүсгэх үр дагавартай байж болно. Дотоодод түүхий эдийн үнийг татаасаар тогтоох нөхцөлд дэлхийн зах зээлд үнэ өндөр байвал экспортын орлого алдагдах бөгөөд төр засагт санхүүгийн өндөр ачаалал ирэх тул баялгийн орлого нэмэгдсэний үр өгөөжийг байхгүй болгох юм.

Төв засгийн газрын хувьд бүс нутгийн хөрөнгө оруулалтын нийгмийн өгөөжийг тунгаан үзэх хэрэгтэй бөгөөд тодорхой бүс нутагт, тухайлбал ажлын байр бий болгох, өсөлтийг хангах хөдөлгүүр болно гэж үзэж буй хотуудад анхаарах шаардлага үүснэ. Түүнчлэн төрөөс нутгийн удирдлагын зарцуулалт хийх үүргийг нь орлогын хуваарилалттай холбож, хариуцлага хүлээх чадавхийг бүрдүүлэхэд идэвх гаргах хэрэгтэй.

Зарим тохиолдолд улсын бусад хэсэгтэй харьцуулахад олборлолтын ойролцоох нутгийн иргэдэд илүү орлогыг хуваарилах асуудлыг төр

Газрын тос экспортлогч орнууд хамгийн их буюу нийтдээ 137 тэрбум америк доллартай тэнцэх хэмжээний татаас өгч байгаа нь дэлхийн газрын тосны нийт татаасын 70 гаруй хувьтай тэнцэж байна. Гэсэн хэдий ч татаас нь ядуурлыг бууруулахад бага нөлөөтэй байна. Бага буюу дунд орлоготой улс орнуудын дундаж дүнгээр өрхүүдийн хамгийн чинээлэг 20 хувь нь хамгийн ядуу 20 хувиас зургаа дахин их татаасыг хүртэж байна.

*Карло Котарелли, Антонет Сайе,  
Масуд Ахмед нар, 2013 он*

засгийн зүгээс авч үзэж болно. Хэсэг бүлгүүд байгаль орчны хохирол, нийгмийн хүндрэл бэрхшээл гэх мэт олборлолтыг дагалдах сөрөг нөлөөг илүүтэйгээр үүрдэг бол түүнээс сэргийлэх эсхүл нөхөн төлбөр олгохыг идэвхтэй эрэлхийлэх ёстой. Цаашилбал, аливаа зөрчилдөөн, нийгмийн хурцадмал байдлыг намжаах зорилгоор төр засаг орлогын зарим хэсгийг олборлолт хийгдэж байгаа нутгийн ойр орчмын иргэдэд хуваарилж болно.

Хэрвээ хөгжилд зориулахаас өмнө шамшигдуулбал орлогыг цуглуулах нь үр дүнгүй болно. Баялгийн засаглалын индекст хамруулж үнэлсэн Камерун болон бусад 19 улсад их хэмжээний орлого үндэсний сан хөмрөгт огт ордоггүй байна.

*Орлогын ажиглагч хүрээлэн, 2013 он*

Гэхдээ баялаг нь улс үндэстний өмчлөлд байгаа бол олборлолтын ойр орчим амьдрах иргэд тухайн улсын бусад иргэдтэй харьцуулахад баялгийн орлогоос илүү хувь хэмжээгээр хүртэх ёстой гэсэн дархан эрх байхгүй бөгөөд төр засгийн зүгээс орон нутгийн хүсэлт шаардлагыг нийт иргэдийн хэрэгцээтэй дэнслэн тэнцвэржүүлэх шаардлага үүсч болно. {Дүрэм 5-аас нутгийн иргэдэд нөхөн төлбөр олгох тухай мөн үзнэ үү.}

## Хөрөнгө оруулалтын үр ашигтай байдлыг хангах

Орлогын удирдлагын хоёр дахь зорилго бол түүнийг хамгийн их нийгмийн өгөөжтэй байхаар хуваарилах явдал юм. Ийм шийдвэрийг гаргахдаа төр засаг зөвхөн санхүүгийн үр өгөөжийг бус, ажлын байр бий болгох, ур чадвар олгох зэрэг эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг мөн харгалзан үзэх хэрэгтэй.

Гол сонголт бол хөрөнгийг дотоодод, эсхүл гадаадад оруулах тухай юм. Дэд бүтэц, төрийн үйлчилгээ сайн хөгжсөн улс оронд дотооддоо нэмж хөрөнгө оруулах нь гадаадад хөрөнгө оруулахаас илүү өгөөжтэй байх магадлал багатай. Гэхдээ ядуу орны хувьд ихэвчлэн гарцгүй болсон буюу хувийн хөрөнгө оруулалтыг татах дэд бүтэц, төрийн үйлчилгээ хангалттай биш байдаг. Гэтэл ийм хөрөнгө оруулалтгүйгээр төр засаг нийтийн дэд бүтэц, үйлчилгээг санхүүжүүлэх орлогыг олж чадахгүй. Баялгийн орлого нь гадаадаас бизнесийн хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн бүтцийн өөрчлөлтийг санхүүжүүлэх замаар ийм байдлаас гарах боломжийг төр засагт олгож байдаг. Ийм нөхцөл байдалтай хөгжиж буй улс орны засгийн газар гадаадад бус дотооддоо хөрөнгө оруулж ялангуяа хувийн бусад хөрөнгө оруулалттай хослууль чадвал үр өгөөж илүү байна. *{Дүрэм 9, 10-аас хөрөнгө оруулалтын саад тотгорыг шийдэхэд орлогыг ашиглах тухай хэсгийг мөн үзнэ үү.}*

Энэ утгаараа бага орлоготой олон орны хувьд баялгийн орлогыг дотоодын эдийн засагтаа хөрөнгө оруулахад зарцуулах нь урт хугацаандаа хамгийн сайн арга зам байх магадлалтай. Гэхдээ нийтийн төслүүдийн сонгон шалгаруулалт, хэрэгжилт муу байж, зардал хөөсрөн нэмэгдэх тохиолдолд дотоодын хөрөнгө оруулалтын огцом өсөлт үр дүнгүй болдог. Ялангуяа дэд бүтэц муутай бол их хэмжээний хөрөнгө зарцуулах хөтөлбөрүүдийн дүнд нэмэгдсэн эрэлтийг хангах чадавхи төр засаг ба бизнесүүдэд хязгаарлагдмал байснаар баялгийн орлогыг эдийн засагт хөрөнгө оруулж ашиглах нь үнэ цэнэтэй капитал бүтээхээсээ илүүтэйгээр инфляци үүсэхэд

хүргэнэ. Ийнхүү “шингээх чадвар” хангалтгүй байх нь төрийн захиргааны чадавхи сул, эсхүл боомтын барилга байгууламж болон хотын тээврийн сүлжээ зэрэг нь хэт ачаалалтай байх гэх мэт бэрхшээлээс шалтгаалж болно. Баялгийн орлого нь эдгээр саад бэрхшээлийг шат дараатай шийдвэрлэх боломжийг төр засагт олгодог. Гэвч үүнийг хэрэгжүүлэхэд цаг хугацаа хэрэгтэй тул эхний ээлжинд илүүдэл орлогыг хилийн чанадад хуримтлалын санд хадгалах, эсхүл гадаад валютын өр зээлийг төлөхөд зориулж болох юм. Ялангуяа гадаад өрийг төлөх нь эдийн засагт ихээхэн үр өгөөжтэй байх боломжтой. Гадаадын өр зээл буурснаар дотоодын шингээх чадварын асуудлыг гаргахгүй байж, улсын зээлжих зэрэглэл болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэхээс гадна хүүгийн түвшинд үзүүлэх нөлөөгөөр дамжин дотоодын хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалт хийхдээ үүрэх зардал буурдаг нь хамгийн чухал юм.

Орлогыг төрийн дэмжлэгтэй зээлдүүлэгч (хөгжлийн банк, ипотекийн зээл олгогч гэх мэт) байгууллагыг санхүүжүүлэхэд ашигласнаар ийм орлогыг захиран зарцуулах шийдвэр гаргах талаар засгийн газраас хавьгүй илүү мэдлэг, мэргэшсэн туршлага хуримтлуулсан байгууллагад асуудлыг шилжүүлэх юм. Эдгээр байгууллагууд хангалттай чадавхитайгаас гадна засаглалын чанд стандартыг бүрдүүлж чадсан тохиолдолд засгийн газрын шийдвэр гаргагчидтай харьцуулахад нийгмийн илүү өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтуудыг сонгох боломжтой юм.

Зарим тохиолдолд хувийн банкууд баялгийн орлогыг санхүүгийн хамгийн өндөр өгөөжтэйгээр зарцуулах ихээхэн чадавхи, хүсэл эрмэлзэлтэй байдаг. Гэхдээ дотоодын хөрөнгө оруулалтын орчинд хүртэх санхүүгийн өгөөж хангалтгүй бол нийгмээрээ санхүүгийн бус өгөөж хүртэх боломжийг үл харгалзан хувийн банкууд хөрөнгийг хилийн чанадад байршуулж болзошгүй. Ийм тохиолдолд баялгийн орлогыг ирээдүйн дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг бүрдүүлэхэд зориулах талаар төр засаг авч үзэх хэрэгтэй.

## ДҮРЭМ 8

### Төр засаг орлогын савалгааг тооцох замаар дотоодын зарцуулалтаа жигдрүүлэх хэрэгтэй.

Олборлох салбараас хараат улс орнуудын нэн тулгамдсан асуудал нь гол төлөв орлогын савалгаа байдаг. Ирээдүйд олох орлого тодорхойгүйгээс өндөр өсөлтийн үед тааруу төлөвлөгдсөн төслүүдэд хэт их хөрөнгө оруулах, харин үнэ эсхүл үйлдвэрлэл буурахад зардлаа огцом танах эрсдэл үүсгэдэг нь төрийн зүгээс хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд бэрхшээл үүсгэдэг. Цаашилбал валютын ханш, инфляци, засгийн газрын зарцуулалтын зэрэг савалгаанаас үүдсэн бизнесийн байгууллагуудын зарцуулалт нь савалгааг улам даамжруулж болно.

Асуудлын хамгийн найдвартай, урт хугацааны шийдэл бол баялгийн олборлолтоос орлогын хамааралтай байхыг багасгах явдал юм. Эдийн засгийг, ялангуяа татварын бааз суурийг олон тулгууртай болгох замаар олборлох салбарын хамаарлаа бууруулснаар нэг үйлдвэрлэлийн нөхцөл байдлаас төр засгийн орлого бүрдэлт хамаарахаа болино. Эдийн засгийн төрөлжилт бол богино хугацааны тогтвортой байдал дээр суурилдаг бөгөөд урт хугацаанд туулах төвөгтэй зам юм. Завсрын гэж болох энэ үйл явцыг удирдахад олборлох салбарын татварын дэглэмийг тогтоох, төсөвт орж, гарч байгаа орлогын урсгалыг зохицуулах, мөн ямар зардал бусдаасаа илүү савалгаатай талаар шийдэх зэрэг төрөл бүрийн арга хэрэгсэл засгийн газрын мэдэлд бий. Эдгээр арга хэрэгслийг хослуулан хэрэглэхийн сацуу суурь институциудыг бэхжүүлэх замаар төр засгийн зарцуулалтын үр дүнтэй хяналтыг баталгаажуулж, эдийн засгаа макро түвшний цочролоос хамгаалах нь зохистой стратеги байж болох юм.

Түүхий эдийн үнийн өөрчлөлт нь түр зуурын эсхүл урт хугацаанд үргэлжлэхийн алины

дохио болохыг мэдэхэд төвөгтэй байдаг нь төр засгийн шийдвэрт хүндрэл учруулдаг. Хэрэв үнийн өөрчлөлт түр зуурын бол төр засаг савалгааг удирдах дээрх арга хэрэгслийн аль нэгийг ашиглах нь тохиромжтой. Харин үнийн өөрчлөлт илүү байнгын шинжтэй бол төр засаг зарцуулалтын урт хугацааны төлөвлөгөөндөө тохируулга хийх талаар бодох нь зүйтэй. Гэхдээ ингэх нь амаргүй бөгөөд төр засгийн шийдвэр гаргагчид тодорхой бус байдлыг ойлгох ёстой.

#### Олборлох салбарын татварын дэглэм нь орлогын савалгаанд хэрхэн нөлөөлөхийг тооцоолох

Үнийн савалгаа орлогын савалгаанд хэрхэн нөлөөлөх нь заримдаа татварын дэглэмийн бүтцээс хамаарах нь бий. Жишээлбэл, нөөц ашигласны төлбөр, хураамжийг ашиглах нь компанийн ашгийн болон өндөр ашгийн татвараас илүүтэйгээр орлогыг хамгаалдаг. Гэхдээ ийм хамгаалалт нь хязгаарлагдмал бөгөөд орлогын дундаж дүнг бууруулахад хүргэж болно. *{Дүрэм 4-өөс Татвар ногдуулалтын тухай мөн үзнэ үү.}*

#### Үнийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах (хэджинг) хэлцлүүдийг ашиглах талаар бодолцох

Зарим үед засгийн газар түүхий эдийн үнийн тодорхойгүй байдлаас хамгаалах санхүүгийн хэлцлээр дамжуулан орлогын уналтын эсрэг даатгагдах боломжтой байдаг бөгөөд үүнийг “хэджинг хэлцэл” гэж нэрлэдэг. Гэхдээ үүнийг богино хугацаанд даатгал хэлбэрээр ашиглах нь тохиромжтой байх ба урт хугацааны хамгаалалт болговол хэт өндөр өртөгтэй байж мэднэ. Богино хугацааны хэджинг хийхэд ч үлэмж зардал гарах бөгөөд үнэ унасан тохиолдолд л өгөөжөө өгдөг.

Энэ утгаараа баялаг ихтэй, бага орлоготой улс орнуудад эдийн засаг, улс төрийн өндөр өртөгтэй байх магадлалтай. Нэгэнт хэджингийг ашиглах бол бусад стратегийг агуулсан холимог багцын хүрээнд хамтатгах нь илүү үр дүнтэй байх болно.

## Гадаадын хөрөнгийг хуримтлуулах ба богино хугацааны зээл авах талаар авч үзэх

Гурав дахь стратеги бол өсөлтийн үед гадаадын хөрөнгийг хуримтлуулах зорилгоор илүүдэл орлогыг санд хуримтлуулж, харин орлогын уналтын үед тэр хөрөнгөө худалдах (хэрэв хангалтгүй бол зээл авах) явдал юм. Сангуудыг тогтворжуулалтын зорилгоор ашиглах нь баялгийг ирээдүй үеийнхэнд зориулан хадгалах илүү урт хугацааны зорилготой хуримтлалын сангаас зарчмын хувьд ялгаатай бөгөөд хөгжиж буй орны хувьд хуримтлал нь тэргүүлэх ач холбогдолтой биш байж болох юм. Практик дээр энэ хоёр чиг үүргийг нэг сан гүйцэтгэж болно. *{Дүрэм 7-оос урт хугацаанд хуримтлал үүсгэх зорилгын тухай мөн үзнэ үү.}*

Дараах гурван шалтгааны улмаас тогтворжуулалтын санд дотоодын компанийн хувьцаа зэрэг дотоодын хөрөнгийг бус гадаадын засгийн газрын үнэт цаас зэрэг гадаад хөрөнгийг хадгалдаг. Нэгдүгээрт, улс орныг зардлын савалгааны сөрөг нөлөөллөөс ангид байлгана. Сангийн хөрөнгийг дотоодод байршуулах нь төсвийн гадуурх зардлыг нэмэгдүүлэхээс бус улс орны нийт зарлагын савалгааг бууруулахгүй. Хоёрдугаарт, дотоодын зарлагыг төсвөөс гадуурх сангаас гаргах үед төсөвт хийгддэг ердийн хяналт, шалгалт орхигдох талтай. Эцэст нь их хэмжээний санхүүгийн урсгал улс оронд орж ирэх үед гадаад валютаар илэрхийлэгдсэн гадаад хөрөнгийн хуримтлалтай байх нь валютын ханшид үзүүлэх нөлөөг хязгаарлахад тустай.

Ирээдүйд олборлох салбарын түүхий эдийн үнэ уналтыг давж гарахад улс оронд хэдий хэмжээний хуримтлал хэрэгтэйг тооцоолох хэцүү. Түүхий эдийн үнийг таамаглахад төвөгтэй учраас

төрийн зүгээс их хэмжээгээр хуримтлал үүсгэх шаардлага тулгарч болно. Сангийн эхний үед ингэвэл хэцүү бөгөөд орлогын зохистой ашиглалт биш байж болзошгүй. Ийм тохиолдолд олон улсын хөрөнгийн зах зээлээс зээл авах нь дээр. Гэхдээ төр засаг хэт их зээлээс үүсэх эрсдэлийг ухамсарлаж, зөвхөн богино хугацаатай зээл авахад анхаарах хэрэгтэй. Хэтдээ төр засаг өрийг нэмэх бус буруулахад чиглүүлэн байгалийн нөөц, баялгийг ашиглах ёстой.

Цаашилбал дотоодод улсын нэгдсэн төсвийн тогтолцооноос гадуур зарцуулалт хийх шийдвэрийг гаргах нь улсын санхүүгийн менежментийг хүндрүүлж эсхүл хариуцан тайлагналын тогтсон журмыг сулруулах тул ийм институци үүсэхээс сэргийлж төр засгаас байгалийн баялгийн аливаа санг үндэсний төсвийн бүрэлдэхүүнд оруулж өгөх хэрэгтэй.

## Урсгал зардлаас өмнө хөрөнгө оруулалтын зардалд өөрчлөлт хийх

Эцэст нь савалгаа даамжирч, засгийн газар нийт зардлыг жигдрүүлж чадахгүй тохиолдолд урсгал зардлаас урьтаж хөрөнгө оруулалтын зардлыг илүү огцом өөрчлөх нь илүү тохиромжтой. Хөрөнгө оруулалтын зардал угаасаа тогтмол биш байдаг, харин урсгал зардлыг хүлээн авагчид буюу тухайлбал нийтийн албанд ажиллагсад цалингаа тогтмол, тодорхой хугацаанд авч байх шаардлагатай. Огцом таналт хийх нь нийтэд таалагдахгүй бөгөөд хэт их нэмсэн цалин, төлбөрийг үнэ унасан үед эргүүлэн бууруулахад улс төрийн хувьд хүндрэлтэй. Гэхдээ санхүүжилт нь хэт савлан бүр зогсох, эсхүл их нэмэгдэх нь хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд ч хохиролтой байдаг тул ийм арга хэмжээг хамгийн сүүлд буюу аргагүй нөхцөлд авах учиртай. Үнийн уналт түр зуурын эсхүл байнгын аль нь болохыг ойлгосны үндсэн дээр ийм шийдвэрийг гаргах нь нэн чухал. Хэрэв үнийн уналт байнгын шинжтэй бол төр засаг хоёр төрлийн зардлыг хоёуланг нь бууруулахаар шийдвэрлэх хэрэгтэй.

## Аливаа арга хэрэгслийг зохистой ашиглахыг баталгаажуулах хяналтыг бий болгох

Ирээдүйн шийдвэр гаргагчид орлогын савалгааг удирдахдаа эдгээр арга хэрэгслийг үр дүнтэй ашиглана гэсэн баталгаа байхгүй. Тухайлбал, тогтворжуулалтын санг гэнэт хоослох, эсхүл өндөр өсөлтийн үед нэмж дүүргэхгүй байхаас гадна өр зээлийн асуудал богино хугацаанд хяналтаас гарах боломжтой. Санхүүгийн гүйлгээг олон нийтийн хяналтаас гадуур, нууцлагдмал байдлаар хийхэд хялбар байдгаас гадна эдгээр арга хэрэгсэл нь нарийн төвөгтэй байдаг тул тэдгээрийг хэрэглэх явц ил тод биш байх эрсдэлтэй. Тиймээс энэ чиглэлээр ил тод байдлыг хангах арга хэмжээ авах нь онцгой чухал. *{Дүрэм 2-оос сайн засаглал бий болгоход хариуцан*

*тайлагнал ямар ач холбогдолтой талаар мөн үзнэ үү.*

Төр засгийн шийдвэрт мониторинг хийхдээ тодорхой зорилт тавих хэрэгтэй. Хэджинг буюу үнийн эрсдэлийг саармагжуулах, хуримтлалын сан үүсгэх, зээлийн хэрэгслүүдийг ашиглахад нь төр засгийг заавал дагаж мөрдөх дүрмээр чиглүүлэх нь тохиромжтой. Эрх баригчид эдгээр дүрмийг өөрчлөмтгий, ялангуяа ирээдүйд үнэ хэрхэн хувьсахыг таамаглахад хүндрэлтэй нөхцөлд хариу арга хэмжээ авахад шаардагдах уян хатан байдалтай дэнслэн авч үзэх ёстой. Тодорхой хэмжээнд уян хатан байдлыг хангахын тулд олон нийтийн хэлэлцүүлэг, албан хяналтан дор ийм дүрмүүдээс хазайх буюу өөрчлөх явдлыг зохицуулах журмыг төр засаг хэрэгжүүлж болно.

# Тогтвортой хөгжилд хөрөнгө оруулах нь



## ДҮРЭМ 9

Төр засаг орлогыг үндэсний болон орон нутгийн түвшинд төрийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломж болгон ашиглах ёстой.

Баялгийн орлого бол төр засгийн хувьд төрийн зарцуулалтыг гүйцэтгэх болон эдийн засгийн цаашдын хөрөнгө оруулалтыг шингээх чадавхийг нэмэгдүүлэх боломж юм. Ийм хүчин чармайлт гаргаснаар улс оронд өндөр өгөөж өгөх дараагийн хөрөнгө оруулалт орж ирэх зам нээгдэхийн хамт өгөөжийг тэгш байдлаар хүргэх боломжийг олгоно.

### Эдийн засаг доройтохоос сэргийлэх байдлаар зарцуулалтын бодлогыг удирдах

Төрийн зарцуулалтын тогтолцоо сул, жижиг эдийн засагтай улс орнуудад үр дүнтэй хөрөнгө оруулах нь бэрхшээлтэй байдаг. Нэгдүгээрт, төслийн шалгаруулалт, үнэлгээг илүү их шаарддаг томоохон төсвийг удирдахад төрийн тогтолцооны чадал хүрэхгүй байж болно. Хоёрдугаарт, баялгийн орлогыг ихээр зарцуулах нь эдийн засагт илүү өргөн хүрээнд нөлөөлж, инфляцийн дарамт үүсгэж, улмаар уг орлогын үнэ цэнийг бууруулах магадлалтай. Гуравдугаарт, баялгийн олборлолт тэгш бус байдлыг нэмэгдүүлэх магадлалтай бөгөөд энэ нь олон нийтийн зүгээс шинэчлэл хийхийг шаардах, цаашлаад зөрчилдөөнд ч хүргэж болно. Эцэст нь ил тод байдал, хариуцан тайлагнал сул байвал зарцуулалтын аль ч үед мөнгө шамшигдахад хүргэж болно.

Идэвхтэй удирдлага үгүй бол их хэмжээний орлогын урсгал улс оронд туслахаасаа илүүтэйгээр хохирол учруулж болно. Энэ утгаараа баялгийн орлого аюул дагуулж болох хэдий ч нөгөө талаас төрийн тогтолцооны сул чадавхитай байдлаас ангижирч, эдийн засгийн шингээх чадварыг бий болгох боломжийг олгодог.

Чад улсын төрийн санд баялгийн олборлолтоос асар их орлого буюу засгийн газрын орлогын 70 хувь нь газрын тосноос орж ирдэг. Харин энэ хөрөнгийг хүний хөгжил болгон хувиргахын оронд төсвийн 18 хувьтай тэнцэх мөнгийг аюулаас хамгаалах салбарт зарцуулсан байдаг. Үүний дүнд өр өсөн нэмэгдэж, тус улс Хүний хөгжлийн индексээр 184 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна.

*Африкийн Дэвшил Зөвлөл, 2013 он*

### Төрийн зарцуулалтын менежментийг сайжруулах

Төрийн зарцуулалтын менежментийг сайжруулах нь зарцуулалтын зохих төлөвлөгөөг сонгох чадварыг нэмэгдүүлэх ба улс төрийн хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэр гаргах хөшүүргийг институциудад бий болгох гэсэн хоёр хэлбэрээр хэрэгжих боломжтой. Институцийн чадавхи сул улс орнууд өнөөгийн зарцуулалтаа шинэчлэх бус зарцуулалтын шинэ төслүүдийн хувьд сайжруулсан, илүү хатуу удирдлагын дүрмийг нэвтрүүлэх нь илүү хялбар байх боломжтой. Засгийн газрын зүгээс төрийн санхүүгийн удирдлагын тогтолцооны хүрээнд дараах зүйлсийг хэрэгжүүлэхийг зорих хэрэгтэй.

Үүнд:

- Зарлага хийгдэх төслүүдийг зохицуулах боломжийг олгохуйц, мөн хувийн хэвшилд илүү тодорхой байдлыг авчрах нээлттэй, олон жилийн төлөвлөгөө
- Өрсөлдөхүйц, нээлттэй, ил тод худалдан авах ажиллагаа (оролцогчдын зүгээс

- хангалттай сонирхол бий тохиолдолд)
- Хөндлөнгийн болон дотоод хяналт
  - Томоохон зарцуулалтын хувьд батлагдахаас нь өмнө өртөг зардлыг нийгмийн болон эдийн засгийн үр өгөөжтэй нь харьцуулсан үнэлэлт
  - Хяналт тавих болон зарцуулалтын үйл явцыг сайжруулахад нь засгийн газарт туслах зорилго бүхий зарцуулалтын төслүүдийн олон нийтэд ил, хараат бус аудит
  - Албан ёсны хяналтыг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах үүднээс зарцуулалтыг хуримтлалын сан болон бусад ижил төрлийн байгууллагаар бус төсвөөр дамжуулах зэрэг орно.

Нигер улс төрийн худалдан авах ажиллагаагаа 1999 онд шинэчилсэн. Үүнээс өмнө жилд дунджаар 300 сая долларыг авлигын шинжтэй үйлдлээс алддаг байсан. Шинэчлэл хийснээс хойш буюу 2001-2007 онд холбооны засгийн газар гэрээний үнийг бууруулах замаар ойролцоогоор 1.5 тэрбум долларыг хэмнэжээ.

*Нгози Оконжо-Ивэла ба Филип  
Осафо-Квако, 2007 он*

Хөрөнгө оруулалтын төслийн өртөг зардлыг бууруулахын тулд улсын хөрөнгө оруулалтын үйл явцыг сайжруулах ба эдийн засаг дахь нийлүүлэлтийн саад тотгорыг арилгах зорилгоор хөрөнгө оруулах нь зүйтэй. Баялгийг олборлох, түүнээс улбаалан хөрөнгө оруулалт болон зарцуулалт хийх нь төрийн хөрөнгө оруулалтын зардлыг дэлхийн жишгээс хэд дахин өндөр түвшинд хүргэхэд шууд бусаар нөлөөлдөг.

Африкийн ихэнх улс орнуудад хангалтгүй дэд бүтэц нь бизнес эрхлэхэд томоохон саад болдог бөгөөд үйлдвэрлэлийн бүтээмжийг 40 орчим хувиар бууруулдаг байна.

*Эскрибано Саэц, Алваро, Хосе Гуаш,  
Хорхе Пена нар, 2010 он*

Төрийн идэвхтэй бодлогоор энэ зардлыг багасгаж, өсөн нэмэгдэх хөрөнгө оруулалтыг шингээх эдийн засгийн чадварыг сайжруулах боломжтой.



## ДҮРЭМ 10

Төр засаг эдийн засгийн төрөлжилтийг сайжруулах болон олборлох салбарын оролцоог хангахад чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй.

Баялгийн орлогыг дотоодын эдийн засгийг өсгөхөд зориулах нь томоохон дэд бүтцээс эхлээд фермерийн аж ахуй зэрэг жижиг төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг үлэмж нэмэгдүүлэхээс онцгой хамааралтай. Гэхдээ баялгийн олборлолтын цаад талд тогтвортой өсөлтийг дэмжих нь баялаг ихтэй олон улс орны хувьд бэрхшээл байсаар ирсэн.

Үүнд нэгдүгээрт, төр засгийн зүгээс саармагжуулах арга хэмжээ аваагүй тохиолдолд их хэмжээний хөрөнгийн урсгал орж ирснээр дотоодын мөнгөн тэмдэгтийн ханш өсөж, улмаар өрсөлдөх чадвар буурч, дотоодын аж үйлдвэрийн болон экспортын салбар хямрах үзэгдлийг “голланд өвчин” гэж нэрлэдэг. Ийм үр дагаврыг анхаарахгүй бол экспортын салбарт оруулах хувийн хэвшлийн хөрөнгө хумигдаж болзошгүй. Түүнчлэн дотоодын бусад салбарт ч хөрөнгө оруулах өртөг өснө. Улмаар эдийн засгийн өсөлт сулрахаас гадна олборлох үйлдвэрлэл бүр илүү жин дарах болсноор эдийн засаг түүхий эдийн үнийн савалгаанд илүү өртөмтгий болж болзошгүй. *{Дүрэм 7, 8-аас эдийн засагт их хэмжээний орлогын урсгалын үзүүлэх нөлөөний тухай мөн үзнэ үү.}*

Хоёрдугаарт, өсөлтөд үзүүлэх баялгийн орлогын нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд төрийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн хэрэгцээнд нийцүүлэх ёстой. Улмаар олборлолтын орлогыг шингээх дотоодын эдийн засгийн чадварыг болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд голлох үүргийг төр засаг гүйцэтгэнэ. Эдийн засгийг дэмжигч нэмэлт орцыг хангахад хувийн хэвшилтэй хамтрах явдал нэн чухал. Тухайлбал, засгийн газар сургууль, эмнэлэгт хөрөнгө зарцуулснаар компаниудад ажиллах хүчний нийлүүлэлт, бүтээмж нэмэгдэнэ.

### Хувийн хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгох

Засгийн газар тодорхой нэг салбарыг онцлохгүйгээр бизнесийн таатай орчныг бий болгох хэрэгтэй. Үүнд хөрөнгө, газар болон хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, дэд бүтэц болон нийтийн хэрэгцээг хангах, мөн ажиллагсдын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн бодлогыг сайжруулах зорилготой шинэчлэл хамаарна. Ялангуяа эдийн засаг дахь саад тотгорыг багасгаснаар хувийн хөрөнгө оруулалт хийхэд гарах зардлыг бууруулж, цаашид хөрөнгө оруулалтыг шингээх эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.

Орлого багатай жижиг улс орнууд нь дангаар болон бүлэглэн ноёрхлоо тогтоосон компаниуд давамгайлсан жижиг зах зээлтэй байдаг бөгөөд тэдгээр нь хөрөнгө ба тоног төхөөрөмжийн үнийг системтэйгээр өсгөх чадвартай байдаг нь хөрөнгө оруулалтыг үргээж байдаг. Зах зээлд шинээр орж ирэгсдийг дэмжих идэвхтэй бодлого явуулснаар ийм бүлэглэлийг задлах боломжтой. Тухайлбал, ийм бодлого нь бизнес шинээр эрхлэх явдлыг хялбаршуулах, мөн бүс нутгийн хэмжээнд нэгдэл үүсгэх болон импортын тоног төхөөрөмжийг борлуулахад үйлчлэх тарифын бус хязгаарлалтуудыг устгаснаар зах зээлийг тэлэх боломжтой.

Хоёр салбарт тусгайлан анхаарах нь зүйтэй бөгөөд эдгээр нь барилга болон санхүүгийн салбар юм. Барилгын салбарын хувьд хотжилт явагдаж буй улс орны хувьд барилга байгууламж нь чухал хөрөнгө оруулалт байх магадлалтай. Гэвч цемент зэрэг барилгын овор ихтэй материалуудыг импортлох нь хэтэрхий өндөр өртөгтэй байх тул дотоод эх үүсвэрээс ханган

нийлүүлэлт хийхийг бизнесүүд хичээнэ. Өмнө нь хөрөнгө оруулалтын хэмжээ бага байсан жижиг эдийн засагт барилгын ажлын нэгжийн өртөг өндөр байдаг бөгөөд барилгын салбар дахь эрэлтийн огцом өсөлт нь энэ өртгийг улам бүр нэмэгдэхэд хүргэж болзошгүй. Барилгын салбарын нэмүү өртгийн хэлхээний үе шатуудыг авч үзээд гацаа үүсгэх саад тотгорыг шийдвэрлэж, мөн тус салбарт бүлэглэн болон дангаар ноёрхох явдлыг эцэслэх нь дээрх өртөг зардлыг бууруулахад тустай.

Дотоодод үйлдвэрлэх бодит боломжгүй, импортлох шаардлагатай барилгын салбарын бүтээгдэхүүний хувьд гаалийн тодорхой тарифыг бууруулбал тустай. Хэдийгээр ингэх нь татварын орлого болон дотоодын нийлүүлэгчдийн хамгаалалтыг бууруулахад хүргэж болох ч шийдвэр гаргагчид үүнийг төрийн болон хувийн хэвшлийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын өсөлтийн үр өгөөжтэй дэнслэн үзэх хэрэгтэй.

Бас санхүүгийн салбарын өсөж дэвших нь чухал. Компаниуд томорч, дотоодын эдийн засагт хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийг эрмэлзэх үед тэдэнд санхүүгийн хоёр төрлийн саад тулгарна. Нэгдүгээрт, хөрөнгө оруулалт хийхэд эхлэлтийн хөрөнгө шаардагдана. Хоёрдугаарт, компани өсөхийн хэрээр тухайн жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө өмнөх жилийн борлуулалтын дүнгээс давах тул ирээдүйд бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шаардагдах санхүүжилт дутагдана. Тиймээс компанид богино хугацааны ажлын хөрөнгийн илүү их санхүүжилт шаардлагатай. Хөгжиж буй эдийн засгийн хувьд дээрх хоёр шалтгаанаар дотоодын санхүүгийн салбарын санхүүжилтийн (болон холбогдох үйлчилгээний) эрэлт хурдацтай өсөх боломжтой. Санхүүгийн салбарыг бэхжүүлж тэлэхэд чиглэсэн бодлого гацааг бууруулах тул улсын орлогыг санхүүгийн салбарт оруулж саадыг богино ба дунд хугацаанд арилгаж, энэ хооронд урт хугацааны бодлогын арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй.

Ботсван улс 1970-аад оны дунд үеэс гол төлөв очир алмаз олборлох салбарын орлогоо ашиглаж ҮНБ-ийхээ таваас дээш хувийг боловсролын салбарт тасралтгүй зарцуулсаар ирсэн. Үр дүнд нь өнөөдөр бүх нийтийн суурь боловсролыг хангаад зогсохгүй дунд боловсролд хамралтын хувь 82 хувь байгаа нь Африк тивийн дунджаас хоёр дахин өндөр үзүүлэлт юм.

*НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан,  
Соёлын Байгууллага, 2012 он*

## Бизнесийн салбарт зорилтот дэмжлэг үзүүлэх эсэхийг шийдвэрлэх

Баялгийн үнэ, үйлдвэрлэлийн эрчимт өсөлт нь олборлох салбараас хэт хамааралтай болох эрсдэл ба олборлохоос бусад салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгаа олон тулгуурт болгох явдлыг дэмжих боломжийг аль алиныг дагуулж байдаг.

Өмнө дурдсанчлан, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх нь олборлох салбараас гадна олон салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлснээр эдийн засгийн төрөлжилтөнд ерөнхийдөө дэмтэй байдаг. Түүнчлэн төр засгаас тодорхой салбар, үйлдвэрлэлийг шууд дэмжих, эсхүл олборлох салбарын хувьд дотооддоо нэмүү өртөг нэмж бий болгох явдлыг дэмжих боломжтой. Гэхдээ ийм бодлого нь салбарыг сонгохдоо улс төржих, өрсөлдөх чадваргүй, хамгаалагдсан компаниуд бий болох зэрэг эрсдэлийг дагуулдаг.

Хэрвээ энэ нь хүчтэй ашиг сонирхлыг бий болгож байгаа бол түүний хамгаалалтыг задлахад хүндрэлтэй байх тул анхнаасаа ийм бодлогоос зайлсхийх нь дээр байж болно.

Эдгээр эрсдэлийг төр засаг үл харгалзан идэвхтэй бодлого явуулахыг сонгосон бол дараах хоёр зарчмыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Хөрөнгө оруулалт нь урт хугацаандаа бизнесийн хувьд ашигтай байх үндэслэл бүхий хүлээлт байх хэрэгтэй. Энэ шалгуурыг хангаагүй хөрөнгө оруулалт үнэ цэнийг бий болгохоосоо илүү сүйтгэж, төрийн сан хөмрөгийг хоослох болно.
- Төрийн дэмжлэг нь бүтэлгүйтэл бус амжилтад хүргэх ёстой. Төр засаг ямар нэг нөхцөл тавигдаагүй дэмжлэгийн багцаас зайлсхийх нь зүйтэй. Гүйцэтгэл хангалтгүй үргэлжилбэл цуцлах үндэслэлтэй шалгуур аливаа дэмжлэгийг дагалдах ёстой. Тодорхой үндэслэлээр цуцлахад ашиг сонирхол бүхий талуудын лобби олонтаа саад болдог тул төр засаг дээд түвшиндээ шийдвэр гаргах, ингэхдээ хэрэглэгч, татвар төлөгч, түүнчлэн бизнесийнхний ашиг сонирхлыг төлөөлөх нийгмийн өргөн хүрээнд зөвлөлдөх шаардлагатай.

### Дотоод агууламжийн зохицуулалтыг ашиглах эсэхээ шийдэх

Олборлох салбар нь дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэхээс гадна олон улсын бизнесийн мэдлэгийг нэвтрүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд түлхэц өгөх боломжтой. Төрийн зүгээс бизнесийн ерөнхий таатай орчныг бий болгох бодлого хэрэгжүүлж салбаруудын ажиллах хүчний чанарыг сайжруулах замаар хувийн хэвшлийг олборлох үйлдвэрлэлтэй холбогдоход нь туслах хэрэгтэй.

Эдгээр ерөнхий бодлого хангалтгүй тохиолдолд олборлох компанийн үйлдвэрлэлийн орцын дотоод агууламж ямар хэмжээтэй байхыг тусгайлан зохицуулах шийдвэрийг төрөөс гаргаж болно. Тухайлбал, концессын гэрээ байгуулах саналдаа олон улсын компаниуд дотоодын ханган нийлүүлэлтийн багцыг хөгжүүлэх болон мэдлэгийг шилжүүлэх үүргийг тусгахыг төрийн зүгээс шаардах, эсхүл шалгаруулалтын дараах хэлэлцээний үед ийм тохиролцоонд хүрэх боломжтой. Дотоодын ханган нийлүүлэгчид олборлох салбарт хангалт хийх өрсөлдөх чадвар

дутмаг тохиолдолд төрийн зүгээс тэднийг олон улсын өрсөлдөөнөөс хамгаалахыг зорьж болох хэдий ч тийм арга хэмжээ түр хугацааных байх ёстой бөгөөд дотоодын нийлүүлэгчид эцсийн дүндээ ижил түвшинд өрсөлдөх тодорхой төлөвлөгөөтэй уялдсан байх шаардлагатай.

Төр засаг мөн олборлох компани, тэдгээрийн олон улсын ханган нийлүүлэгчдээс дотоодын аж ахуйн нэгжүүдэд технологи, ур чадварыг шилжүүлэн нэвтрүүлэх явдлыг дэмжихийг хүсэж болно. Сургалтын байр тоног төхөөрөмж, судалгаа, хөгжлийн чиглэлийн хөрөнгө оруулалт гэх мэт загварууд нь компанийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дотоодын бизнесийн чадавхийг нэмэгдүүлж болно. Эдгээрийг олборлолтын компаниудын нягт оролцоотойгоор хэрэгжүүлэх нь илүү үр өгөөжтэй байна. Цаашилбал төр засгийн зүгээс дотоодын ажиллах хүчний наад захын шаардлагыг менежер, ажиллагсдын түвшинд тогтоож болох бөгөөд ийм шаардлагыг торгууль, урамшуулал бүхий мониторинг, тайлагналын системээр дамжуулан баталгаажуулах боломжтой.

Гэхдээ дотоод агууламжийг дэмжих бодлого нь бизнес эрхлэгчид болон ажиллах хүчинд таатай орчин бүрдүүлэх бодлогыг орлох бус эдийн засгийн ерөнхий шинэчлэлтэй уялдан хэрэгжих ёстой. Цаашилбал хорогдож байдаг хөрөнгөд суурилсан дотоодын үйлдвэрлэлийн тогтвортой ирээдүй нь цаашид илрүүлэх нөөц баялгаас, эсхүл эцсийн дүндээ гадаадын зах зээлд дотоодын компаниудын өрсөлдөх чадвараас хамаарна. Төр засаг энэ эрсдэлийг тооцох ёстой. Олборлох үйлдвэрлэлд оролцох эсхүл ханган нийлүүлэх явдлыг дэмжихийн зэрэгцээ төр засаг бүр эхнээсээ эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхийг дэмжих хэрэгтэй. Энэ үүднээс эрх баригчид “олборлох туршлага”-д тулгуурлан хөгжүүлэх боломжтой дотоодын чадавхийн төрлүүдийг судлан үзэж, илүү тогтвортой байх бусад салбарт нэвтрүүлж болох чадавхид анхаарлаа төвлөрүүлэх боломж бүрдэнэ.

## Гүн боловсруулалтыг дэмжих эсэхээ тодорхойлох

Баялаг ихтэй улс орнууд газрын тос боловсруулах гэх мэт гүн боловсруулалтын үйл ажиллагаа хийх боломжуудыг үнэлж үзэх хэрэгтэй. Аливаа улс ахуйн болон эдийн засгийн үйл ажиллагаанд чухал шаардлагатай эрчим хүч, нөөцийн хойшлуулушгүй хэрэгцээгээ хангаж чадахгүй байж болох бөгөөд олборлосон баялаг нь ийм хэрэгцээг хангах, мөн эдийн засгийн хөгжлийг дэмжих боломжийг олгодог. Зарим тохиолдолд төрийн зүгээс баялгийг дотооддоо гүн боловсруулахыг тэргүүн ээлжийн хөрөнгө оруулалт гэж үздэг. Төр засгаас гүн боловсруулалт хийх үйлдвэрлэлд дотоодын оролцоог дэмжих эсэх нь гадаад дахь боловсруулах үйлдвэр рүү болон түүнээс буцаан зөөвөрлөх тээврийн зардлаас хэмнэх хөрөнгө болон бусад өгөөжийг гүн боловсруулах дотоодын үйлдвэрийг төрөөс дэмжихэд гарч болзошгүй сул талуудтай дэнслэн үзэхээс голлон хамаарна. Үүнд төрийн сан хөмрөгийг хөрөнгийн багтаамж ихтэй боловсруулах үйлдвэрт зарцуулснаас алдагдах бусад боломжийн өртөг, импортын ур чадвар, тоног төхөөрөмжөөс хараат байх, мөн

бусад салбартай харьцуулахад шинээр бий болгох ажлын байр хязгаарлагдмал байх зэрэг хамаарна.

Овор ихтэй түүхий эдийн хувьд, мөн түүхий эдийн дотоодын эрэлт их тохиолдолд боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь илүү үндэслэлтэй байдаг. Ялангуяа байгалийн хийг онцлох хэрэгтэй, учир нь эдийн засгийн хөгжлийн угтвар нөхцөл болох эрчим хүч үйлдвэрлэлтэй салшгүй холбоотой. Хийг тээвэрлэх зардал ихэвчлэн өндөр байдаг учраас дотоодын эрчим хүч үйлдвэрлэгчдэд өрсөлдөхүйц эх үүсвэр байх боломжтой. Хийгээр эрчим хүч үйлдвэрлэх нь бусад хувилбарууд болох газрын тос, нүүрс, цөмийн эх үүсвэр, түүнчлэн усан цахилгаан станц болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй харьцуулахад хөрөнгийн багтаамж багатай, мөн хийн хэрэглээ нь нүүрс хүчил бага ялгаруулах эрчим хүчний технологид шилжих явдалд дөхөмтэй. Дээрээс нь дотоодын зах зээлийг хангах тогтолцоо нь газрын тос олборлолтоос бий болсон илүүдэл хийг аюулгүй, үр ашигтай, мөн байгаль орчинд халгүй нөхцөлөөр ашиглах боломжийг олгодог.

# Баялгийн засаглалын олон улсын үндэс



## ДҮРЭМ 11

### Компаниуд байгаль орчин, нийгэм, хүний эрхийн хамгийн дээд түвшний стандартууд, мөн тогтвортой хөгжлийг эрхэмлэх ёстой.

Олборлох салбарын хувийн компаниуд нь хуульд заасан наад захын шаардлагаас гадна байгаль орчин, нийгэм, хүний эрхийн хамгийн өндөр стандартыг баримтлах, авлигаас зайлсхийх, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах, төсөлтэй холбоотой зохих мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгох зэрэг алхмыг хийх ёстой.

Компаниуд өөрийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй байгаль орчин, нийгэм, хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, шийдвэрлэх үүргийг хүлээх, мөн эдгээр үүргийг ажиллаж буй улсынхаа төр засгийн өмнө хариуцан тайлагнах ёстой. Түүнчлэн компаниуд өөрийн түнш, гэрээлэгч болон туслан гэрээлэгч нарт мөн тийм үүрэг хүлээхийг шаардах хэрэгтэй. Үүнд арьсны өнгө, гарал угсаа, хүйс, нас болон бусад онцлог бүхий хүмүүст тухайлан учирч болзошгүй орон нутаг, бүсийн хэмжээний нөлөөллийн үнэлгээ, менежментийн асуудал хамаарна. Төр засаг болон компаниудын аль аль нь уугуул иргэдийн эрхийг бүрэн харгалзах ёстой. Чөлөөтэй, урьдчилж танилцуулсан зөвшөөрлийг олборлолт хийхдээ авсан байх шаардлагыг хуулиар тавьдаг бол уугуул иргэдийн газар нутагт аливаа ажил явуулахаас өмнө компаниуд зөвшөөрөл авсан байх ёстой бөгөөд цаашид олборлох үйл ажиллагааны нөлөөнд ихээхэн автаж болзошгүй нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллаж, зөвлөлдөж байх нь зүйтэй. Компани төсөл хэрэгжих бүх хугацаанд ийм үүргийг биелүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүг гаргах ёстой бөгөөд олборлох төсөл хаагдах зэрэг орлого багасах, эсхүл огт орлогогүй болсон цагт хэрхэх талаар төлөвлөсөн байх ёстой.

#### Авлигын үйлдлийг тэвчих

Үндэстэн дамнасан компаниуд тухайн улсын үндэсний хууль тогтоомж, олон улсын хэлэлцээр, хэм хэмжээг сахин ажиллах ёстой бөгөөд эдгээрт төрийн албан тушаалтныг хахуульдах нь гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрөх нь нэмэгдсээр байна. Компани бүр авлигын асуудлаар тодорхой дотоод бодлоготой байх шаардлагатай ба үүнд ажиллагсад, гэрээлэгчид, туслан гэрээлэгчид эсхүл тэдгээрийн төлөөлөгчдийн авлигын үйлдлийг урьдчилан сэргийлж, шийтгэл ногдуулах журам, хяналтыг тогтоох ёстой. *{Дүрэм 2-оос хариуцан тайлагнах тухай мөн үзнэ үү.}*

#### Тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах

Компаниуд олборлох үйл ажиллагаанаас олох боломжтой үр өгөөжийг дээд хэмжээнд хүргэхэд чиглэсэн баялгийн эзэн улс орны төр засгийн хүчин чармайлтыг дэмжин ажиллах ёстой. Жишээлбэл, тухайн улсын хувьд дотоод агууламжийг хөгжүүлэх нь зохистой байгаа бол дотоодын үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай урт хугацааны үүргийг хүлээлгэх талаар төр засаг компаниудтай хамтран ажиллаж болно. Бас компанийн хамтын ажиллагаа орон нутгийн ханган нийлүүлэгчдийн чанарыг сайжруулахад чиглэсэн сургалт, ажил эрхлэлтийн санаачилга зэрэг хэлбэртэй байж болно. Ийм хамтын ажиллагаа нь зөрчилдөөнийг намдааж, чадавхийг бэхжүүлэхэд чухал. *{Дүрэм 10-аас дотоод агууламжаар дамжуулан эдийн засгийг хөгжүүлэх тухай мөн үзнэ үү.}*

Олборлох үйл ажиллагаа, түүний нөлөөллийг бууруулахтай шууд хамааралгүй төмөр зам, авто

замын дэд бүтэц зэрэг туслах бүтээгдэхүүн, үйлчилгээг компаниуд хангаж байгаа бол олборлох төслийн үйл ажиллагааны стандарттай нийцүүлж хэрэгжүүлэх, мөн төсөл хэрэгжих хугацаа дууссан ч арчилгаа үйлчилгээг хангах, эсхүл бусдад уг үүргийг хариуцлагатайгаар шилжүүлэх хэрэгтэй.

Гэрээний тогтвортой байдлын хувьд төр засгаас компанид гаргаж өгөх баталгаа нь үл ялгаварлах тухай заалтуудаар хязгаарлагдах ёстой. Компаниуд хүний эрх, байгаль орчны хяналт, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа, мөн ажиллах хүчний асуудлаар үйлчилж буй хууль тогтоомж, зохицуулалтын хүрээнд өөрчлөлт оруулан тусгайлсан хөнгөлөлт эдлэх, эсхүл нөхөн олговор авах хүсэлт гаргах, хүлээлттэй байх, мөн ийм зохицуулалтыг хүлээн авах ёсгүй.

## Төслийн талаар зохих мэдээллээр хангах

Компаниуд нийтэд ил тайлагнах шаардлагуудыг дэмжиж, биелүүлэх ёстой. Үүнд төр засаг, компаниудын хооронд байгуулах гэрээнүүд хамаарах ба эдгээрт санхүүгийн нөхцөлүүдийг ойлгоход хялбараар тусгасан байх нь зүйтэй. Тодорхой хугацааны хязгаартайгаар мэдээллийг нууцлах цорын ганц үндэслэл нь тухайн үед болон ойрын ирээдүйд явагдах хэлэлцээнд аль нэг талын байр суурьт шууд нөлөөлж болох бизнесийн тусгайлан өмчилсөн мэдээлэлтэй холбоотой байж болно. Компаниуд ард иргэд, тэдний олон улсын хэмжээнд хамгаалагдсан хүний эрх, мөн холбогдох үнэлгээний өгөгдөл, урьдчилан сэргийлэх, нөлөөг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө зэрэг байгаль орчинтой холбоотой тайланг хялбар олж авах боломжийг хангах ёстой. Мэдээлэл нь шинэ, хүртээмжтэй, хэрэглэж болохуйц байх тал дээр төр засаг ба компаниуд хамтран ажиллах нь зүйтэй. *{Дүрэм 2-оос ил тод байдлын тухай мөн үзнэ үү.}*

## ДҮРЭМ 12

Төр засаг болон олон улсын байгууллагууд тогтвортой хөгжлийг дэмжих стандартуудыг сайжруулан жигдрүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих ёстой.

Олборлох салбарт нөлөөлөх бодлогыг санхүүжүүлдэг, эсхүл түүнд нөлөө үзүүлдэг засгийн газар, олон улсын байгууллагууд нь баялаг ихтэй улс орны төр засгийн гаргасан шийдвэрийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Олборлох компанийн бүртгэлтэй улс орны үндэсний зохицуулагчдаас гадна Дэлхийн банк, Олон улсын валютын сан (мөн тэдгээрийн зээлийн агентлагууд), хандивлагч засгийн газрууд, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, НҮБ-ын агентлагууд, экспортын зээлийн агентлагууд, Африкийн холбоо, Европын холбоо, Их найм, Их хорь, мөн бусад олон улсын байгууллагууд, түүнчлэн даян дэлхийн санхүүгийн хамтын нийгэмлэг үүнд хамаарна. Бас эдгээр тоглогчид бодлогоо сайжруулах, улс орнууд болон компаниудад мониторинг хийх шахалт үзүүлэхэд олон улсын иргэний нийгмийн байгууллагууд мөн чухал үүрэг гүйцэтгэдэг. *{Дүрэм 2-оос ил тод тайлагнах шаардлагын тухай мөн үзнэ үү.}*

Олон улсын хамтын нийгэмлэгээс дэлхий даяар баялгийн олборлолтын засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлж чадах гол чиглэлүүдийг дор дурдав.

### Олборлох үйлдвэрлэлийн олон нийтэд ил тайлагнах шаардлагуудыг дэмжиж, хянаж, хэрэгжүүлэх

Засгийн газрууд, олон улсын байгууллагууд болон бусад талууд нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн олон улсын багц стандарт бий болгож мөрдүүлэх, түүнчлэн гэрээний нөхцөлүүдийг ил болгох зэргээр ил тод байдлыг дээшлүүлэх боломжтой. Хайгуулын тусгай зөвшөөрөл авах үеэс эхлээд төслийн хаалт хүртэлх олборлолтын төсөл үргэлжлэх нийт хугацаанд олон нийтэд

мэдээллийг ил тайлагнах нь иргэд, хөрөнгө оруулагчдын зүгээс төр засаг болон компаниудад хариуцлага тооцоход туслах чухал механизм юм. Түүнчлэн дэлхийн түвшний заавал ил тайлагнах шаардлагуудыг хуульчлахаас гадна баялаг ихтэй хөгжиж буй улс орнууд үндэсний болон олон улсын түвшинд талуудын дунд яриа хэлэлцүүлэг өрнүүлэхийг дэмждэг сайн дурын нэмэлт стандарт байдлаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд нь дээрх байгууллагууд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

### Олборлох үйлдвэрлэлийн төслүүд хүний эрхийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцэх явдлыг хангах

Засгийн газар өөрийн улсын нутаг дэвсгэрт бүх компани хүний эрхийг дээдлэх шаардлагыг тодорхой тогтоож өгөх ёстой бөгөөд үүнд наад зах нь Олон улсын хүний эрхийн билл болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хүрэн дэх суурь зарчмууд ба эрхүүд хамаарна.

НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчим (НҮБУЗ)-ын дагуу олборлох үйлдвэрлэлийн төслүүдийн хүрээнд тухайн улс орнууд хүний эрхийг хамгаалах үүргээ биелүүлэхэд дэмжиж туслах болон компаниуд хүний эрхийг хүндэтгэх үүргээ дагаж мөрдөх явдлыг хангах ёстой.

Олборлох салбарыг санхүүгээр болон баталгаа гарган дэмжигч талууд олборлолтын төслөөс үүдсэн хүний эрхийн болзошгүй болон гарсан зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн НҮБУЗ-тай нийцсэн магадлан лавлагааны журмыг шаардах нь зүйтэй. Хүйс, арьсны өнгө, нас, бусад хүчин зүйлсээр тодорхойлогдох ялгамжтай нөлөөлөлд тусгайлан анхаарах хэрэгтэй.



## Олборлолтын төслүүд байгаль орчин, нийгмийн стандартад нийцэх явдлыг хангах

Олборлох үйлдвэрлэл нь нутгийн иргэдийн амьдралын чанар, орон нутгийн хийгээд дэлхийн байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох юм. Олон улсын байгууллагууд ийм нөлөөллийг хязгаарлахуйц төслийн үйл ажиллагааны зохистой стандартууд, түүнчлэн нөлөөллийн үнэлгээг тогтоож дэмжих, урамшуулах эсхүл шаардах хэрэгтэй. Экспортын зээлийн агентлаг, төрийн болон хувийн хэвшлийн зээлдүүлэгчдийн зүгээс магадлан лавлагааг, түүнчлэн олон улсын байгаль орчны болон нийгмийн стандартуудтай нийцэх байдлын мониторинг, тайлагналыг шаардах нь зүйтэй. НҮБ, Олон улсын санхүүгийн корпораци зэрэг олон улсын цөөнгүй байгууллага уугуул иргэдэд хамгаалах шаардлагатай онцгой эрхүүд байдгийг хүлээн зөвшөөрдөг. *{Дүрэм 5-аас нийгэм, байгаль орчны асуудлуудын талаар мөн үзнэ үү.}*

Хууль бус санхүүгийн урсгал нь хөгжиж буй улс орнуудад жил тутам нэг их наяд долларын өртөгтэй гэсэн тооцоо байдаг нь тусламжаар авдаг нэг доллар тутамд 10 доллар байх хэмжээ юм.

*Дэв Кар ба Дэвон Кратрайт-Смит, 2009 он*

## Хууль бус санхүүгийн урсгал, авлигыг бууруулах

Хууль бус санхүүгийн гүйлгээг багасгах, үнэ шилжилтийн зохисгүй ашиглалт, мөн татварын диваажинг ашиглах болон татвараас зайлсхийх буюу зугтах бусад арга хэрэгслийг хязгаарлах тал

дээр олон улсын байгууллагууд илүү ихийг хийх ёстой. Үүнд банкны хяналт зохицуулалт, мөн банкны болон үнэт цаасны бүх бүртгэлийн хувьд өмчлөгчийг баталгаажуулах зэрэг орно. Баялгийн гэнэтийн ашиг ихтэй улс орнуудад хөрөнгө завших үзэгдэл бүр их давамгайлдаг бөгөөд хууль бус үйлдэл илэрсэн тохиолдолд хулгайлагдсан хөрөнгийг царцаах болон эргүүлэн авахыг олон улсын байгууллагууд шаардах буюу дэмжих нь зүйтэй. Цаашлаад олон улсын байгууллагууд авлига, хээл хахуулийг бууруулах, энэ төрлийн хэргийн эсрэг хүчтэй хууль тогтоомж ба түүний хэрэгжилтийг хангах тал дээр хамтран ажиллах хэрэгтэй. *{Дүрэм 4-өөс татварын зөрчил, Дүрэм 7-оос орлогын урсгалын талаар мөн үзнэ үү.}*

## Олборлох үйлдвэрлэлийн үр чадварын солилцоо ба цар хүрээг өргөжүүлэн дэмжих

Баялаг ихтэй хөгжиж буй олон улс орон нөөц баялгаа тогтвортой, оролцоотой хөгжил болгоход шаардагдах үндсэн чадавхийг хуримтлуулж амжаагүй байна. Олон улсын байгууллагууд болон төр засгууд эдгээр улс орны засгийн газар, хууль тогтоох байгууллага, хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн чадавхийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд хүчин чармайлтыг зөвшилцөж зохицуулах ёстой. Байгалийн баялгийн тунхаг, Африкийн уул уурхайн алсын хараа зэрэг хэм хэмжээг тогтоосон хүрээ нь янз бүрийн талуудад баялгийн засаглалын талаарх хандлагаа уялдуулан зохицуулах болон жигдлэхэд тустай.

Дээр тодорхойлсон бүх чиглэлээр стандартуудыг сайжруулан жигдлэхийн тулд төр засгийн болон олон улсын байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй.

## КЭЙС ЖИШЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖУУД

Africa Progress Panel. “Equity in extractives: stewarding Africa’s natural resources for all.” 2013.

Cottarelli, Carlo, Antoinette Sayeh and Masood Ahmed. “Energy subsidy reform: Lessons and implications and the International Energy Agency.” International Monetary Fund, 2013.

Escribano, Alvaro, J. Luis Guasch, and Jorge Pena. “Assessing the impact of infrastructure quality on firm productivity in Africa: cross-country comparisons based on investment climate surveys from 1999 to 2005.” World Bank Policy Research Working Paper Series, 2010.

Gylfason, Thorvaldur. “Natural resources, education, and economic development.” *European Economic Review* 45(4): 847-859. 2001.

International Monetary Fund. “Botswana: Selected issues.” IMF Country Report No. 12/235. 2012.

Kar, Dev and Devon Cartwright-Smith. “Illicit financial flows from developing countries: 2002-2006.” *Global Financial Integrity*, 2009.

Okonjo-Iweala, Ngozi, and Philip Osafo-Kwaako. “Nigeria’s Economic Reforms: Progress and Challenge.” Brookings Institution, 2007.

Revenue Watch Institute. “The 2013 Resource Governance Index: A measure of transparency and accountability in the oil, gas and mining sector.” 2013.

United Nations Educational, Scientific, and Cultural Organization. “Youth and Skills: Putting Education to Work.” 2012.

World Bank Development Indicators. <http://data.worldbank.org>.

# ТАЛАРХАЛ

## БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ТУНХАГИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



Эрнесто Седило  
*Ernesto Zedillo*  
(Дарга)



Абдулатиф  
Ал-Хамад  
*Abdulatif*  
*Al-Hamad*



Луйза Диогу  
*Luisa Diogo*



Мо Ибрахим  
*Mo Ibrahim*



Шенгман Занг  
*Shengman Zhang*

## БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ТУНХАГИЙН ТЕХНИКИЙН ЗӨВЛӨХ БҮЛЭГ

Майкл Спенс  
*Michael Spence* (Дарга)

Лукман Ахмад  
*Luqman Ahmad*

Олу Ажакайе  
*Olu Ajakaiye*

Салим Али  
*Saleem Ali*

Жо Амоако-Туффур  
*Joe Amoako-Tuffour*

Жозеф Белл  
*Joseph Bell*

Жонатан Берман  
*Jonathan Berman*

Франсуа Бургинион  
*François Bourguignon*

Абу Брима  
*Abu Brima*

Пол Коллье  
*Paul Collier*

Роберт Конрад  
*Robert Conrad*

Питер Эйген  
*Peter Eigen*

Ибрахим Элбадави  
*Ibrahim Elbadawi*

Магнус Эрикссон  
*Magnus Ericsson*

Мишель Фосс  
*Michelle Foss*

Родриго Фуэнтес  
*Rodrigo Fuentes*

Гэвин Хейман  
*Gavin Hayman*

Марк Хенстриж  
*Mark Henstridge*

Кристин Жохарт  
*Christine Joarth*

Шейла Хама  
*Sheila Khama*

Карин Лиссакерс  
*Karin Lissakers*

Кэтрин МакФейл  
*Kathryn McPhail*

Чарльз Макферсон  
*Charles McPherson*

Серж Михайлоф  
*Serge Michailof*

Кит Майерс  
*Keith Myers*

Хосе Антонио Окампо  
*José Antonio Ocampo*

Вилли Олсен  
*Willy Olsen*

Тони Пол  
*Tony Paul*

Майкл Росс  
*Michael Ross*

Андреа Шемберг  
*Andrea Shemberg*

Чуквума С. Солудо  
*Chukwuma C. Soludo*

Андрес Веласко  
*Andrés Velasco*

Энтони Венейблс  
*Anthony Venables*

Алберт Зефук  
*Albert Zeufack*

## БУСАД ОРОЛЦОГЧИД

Филипп Даниэл (Олон улсын валютын сан)  
*Philip Daniel (International Monetary Fund)*

Ана Мариа Эстэвэс (Уул уурхай дахь нийгмийн хариуцлагын төв)  
*Ana Maria Esteves (Centre for Social Responsibility in Mining)*

Жон Хобс (Даян дэлхийн байгаль орчны сан)  
*Jon Hobbs (World Wide Fund for Nature)*

Валери Марсэл (Чатхам хауз)  
*Valérie Marcel (Chatham House)*

Мартин Сканкэ (Сканкэ Консалтинг)  
*Martin Skancke (Skancke Consulting)*

Уул уурхай, металлын олон улсын зөвлөл (*International Council on Mining and Metals*)-ийн ажилтнууд ба гишүүд

## БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ТУНХАГИЙН АНХНЫ ХУВИЛБАРЫН ОРОЛЦОГЧИД

Мартин Абрэгу (Фордын сан)  
*Martin Abregu (Ford Foundation)*

Крис Адам (Баялаг ихтэй улс орны эдийн засгийн шинжилгээний Оксфордын төв)  
*Chris Adam (Oxford Centre for the Analysis of Resource Rich Economies)*

Ингилаб Ахмадов (Хазарын их сургууль)  
*Ingilab Ahmadov (Khazar University)*

Жэйн Аллэн (Төлснөө нийтэл)  
*Jane Allen (Publish What You Pay)*

Клайв Армстронг (Олон улсын санхүүгийн корпораци)  
*Clive Armstrong (International Finance Corporation)*

Махамүдү Баумиа (Африкийн хөгжлийн банк)  
*Mahamudu Bawumia (African Development Bank)*

Хани Бэсада (Норд-Сауд хүрээлэн)  
*Hany Besada (North-South Institute)*

Алекс Бэсоби (Шийдвэрлэх баялаг)  
*Alex Bescoby (Critical Resource)*

Сэм Бикерстэд (Их Британийн Олон улсын хөгжлийн яам)  
*Sam Bickersteth (UK Department for International Development)*

Чарльз Бланд (Би Жи групп)  
*Charles Bland (BG Group)*

Кэвин Борэр (Хивлэтийн сан)  
*Kevin Bohrer (Hewlett Foundation)*

Бонны олон улсын шилжилтийн төв  
*Bonn International Center for Conversion*

Вики Бауман (Рио Тинто)  
*Vicky Bowman (Rio Tinto)*

Лукас Бретшгэр (И Ти Эйч Цюрих-ийн Эдийн засгийн судалгааны төв)  
*Lucas Bretschger (Center of Economic Research at ETH Zurich)*

Силвио Кация Бава (Полис хүрээлэн)  
*Silvio Caccia Bava (Polis Institute)*

Питэр Камерон (Дандигийн их сургууль)  
*Peter Cameron (University of Dundee)*

Жулио Карини (Даян дэлхийн гэрч)  
*Giulio Carini (Global Witness)*

Крис Карол (Жон Хопкинсийн их сургууль)  
*Chris Carrol (Johns Hopkins University)*

Алмира Кэммэл (Даян дэлхийн гэрч)  
*Almira Cemmell (Global Witness)*

Жан Пиер Чабо (Эксплорим)  
*Jean Pierre Chabot (Explorim)*

Албино Чол Тик (Өмнөд Суданы Засгийн газар)  
*Albino Chol Thiik (Government of South Sudan)*

Айдан Дави (Уул уурхай, металлын олон улсын зөвлөл)  
*Aidan Davy (International Council on Mining and Metals)*

Шанта Дэваражан (Дэлхийн банк)  
*Shanta Devarajan (World Bank)*

Кумба Дукорэ (Африкийн хөгжлийн банк)  
*Coumba Doucoure (African Development Bank)*

Жэми Драмонд (НЭГ)  
*Jamie Drummond (ONE)*

Софи Дурхам (Шийдвэрлэх баялаг)  
*Sophie Durham (Critical Resource)*

Эндрю Эдж (Австралийн тусламж)  
*Andrew Edge (AusAid)*

Ричард Эфил Симплисио (Өмнөд Суданы Засгийн газар)  
*Richard Efil Simplicio (Government of South Sudan)*

Кирил Элбэрс (Дэлойт)  
*Cyril Elbers (Deloitte)*

Виесэ Элферич (Нидерландын Гадаад хэргийн яам)  
*Wiesje Elfferich (Ministry of Foreign Affairs, Netherlands)*

Оливер Элэфсэн (Симпрентис)  
*Olivur Ellefsen (Simprenntis)*

Хью Эллиот (Англо-Американ)  
*Hugh Elliott (Anglo American)*

Байгаль орчныг хамгаалах зөвлөл  
*Environmental Defence Council*

Марк Эссэкс (Оксфордын бодлогын менежмент)  
*Mark Essex (Oxford Policy Management)*

Роб Фуулкс (Шийдвэрлэх нөөц)  
*Rob Foulkes (Critical Resource)*

Питэр Франкэнтал (Амнести Интернэшнл)  
*Peter Frankental (Amnesty International)*

Стивэн Фрайз (Шэлл)  
*Steven Fries (Shell)*

Николас Гарэт (Ресурс консалтинг үйлчилгээ)  
*Nicholas Garrett (Resource Consulting Service)*

Ян Гари (Оксфам)  
*Ian Gary (Oxfam)*

Кристофер Госс (Олон улсын санхүүгийн корпораци)  
*Christopher Goss (International Finance Corporation)*

Илоди Грант-Гуди (Би Пи)  
*Elodie Grant-Goodey (BP)*

Сачин Гупта (Оксфордын бодлогын менежмент)  
*Sachin Gupta (Oxford Policy Management)*

Торвалдур Гилфасон (Исландын их сургууль)  
*Thorvaldur Gylfason (University of Iceland)*

Дан Хаглунд (Оксфордын бодлогын менежмент)  
*Dan Haglund (Oxford Policy Management)*

Алан Холл (Даян дэлхийн усны түншлэл)  
*Alan Hall (Global Water Partnership)*

Жэймс Хамилтон (Дюкийн их сургууль)  
*James Hamilton (Duke University)*

Шелли Хан (АНУ-ын Европ дахь аюулгүй байдал, хамтын ажиллагааны комисс)  
*Shelly Han (US Commission on Security and Cooperation in Europe)*

София Хардинг (Төлснөө нийтэл)  
*Sophia Harding (Publish What You Pay)*

Кэн Хэншоу (Нийгмийн акци)  
*Ken Henshaw (Social Action)*

Ричард Хэнвууд (Секор Католик)  
*Richard Henwood (Secours Catholique)*

Адриан Хэвит (Олон улсын хөгжлийн хүрээлэн)  
*Adrian Hewitt (Overseas Development Institute)*

Сэзар Хидалго (Харвардын их сургууль)  
*Cesar Hidalgo (Harvard University)*

Тронд Хьорунгдал (Норвегийн хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг)  
*Trond Hjørungdal (Norwegian Agency for Development Cooperation)*

Жо Инграм (Норд-Сауд хүрээлэн)  
*Joe Ingram (North-South Institute)*

Карим Исмаил (Олон улсын валютын сан)  
*Kareem Ismail (International Monetary Fund)*

Майкл Ярвис (Дэлхийн банк)  
*Michael Jarvis (World Bank)*

Клод Кабэмба (Өмнөд Африкийн баялгийн ажиглагч)  
*Claude Kabemba (Southern Africa Resource Watch)*

Розалин Кайниа (Туллов Ойл)  
*Rosalind Kainyah (Tullow Oil)*

Кай Кайзэр (Дэлхийн банк)  
*Kai Kaiser (World Bank)*

Масуд Каршенас (Дорнын ба Африк судлалын сургууль)  
*Massoud Karshenas (School of Oriental and African Studies)*

Луи Касекендэ (Угандын төв банк)  
*Louis Kasekende (Bank of Uganda)*

Уиллиам Кингсмил (Бодлогын практик)  
*William Kingsmill (Policy Practice)*

Мартина Киркбергэр (Оксфордын их сургууль)  
*Martina Kirchberger (University of Oxford)*

Амсара Клайн (Сайнсис По)  
*Amsara Klein (Sciences Po)*

Ларс Коч (Бонны олон улсын хараат бус сургууль, ИБИС)  
*Lars Koch (Independent Bonn International School, IBIS)*

Грегори Костырски (Канадын гадаад харилцаа, олон улсын худалдааны яам)  
*Gregory Kostyrsky (Foreign Affairs and International Trade Canada)*

Синди Крун (Дэлхийн банк)  
*Cindy Kroon (World Bank)*

Валерий Крюков (Эдийн засгийн дээд сургууль, Москва)  
*Valeriy Kryukov (Higher School of Economics, Moscow)*

Пэр Куровски (Петрополитан)  
*Per Kurowski (Petropolitan)*

Эндрю Лоусон (Фискус)  
*Andrew Lawson (Fiscus)*

Терье Линд (Норвегийн засгийн газар)  
*Terje Lind (Government of Norway)*

Даниэл Литвин (Шийдвэрлэх баялаг)  
*Daniel Litvin (Critical Resource)*

Соня Малдар (Олон улсын хөгжлийн төлөө католик тусламж)  
*Sonya Maldar (Catholic Aid for Overseas Development)*

Адил Малик (Оксфордын их сургууль)  
*Adeel Malik (University of Oxford)*

Ричард Мэннинг (Африкийн эдийн засаг судлалын төв)  
*Richard Manning (Centre for the Study of African Economies)*

Жон Метцгэр (Даян дэлхийн усны түншлэл)  
*John Metzger (Global Water Partnership)*

Ионас Мобэрг (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга)  
*Jonas Moberg (Extractive Industries Transparency Initiative)*

Саймон Мосс (Даян дэлхийн ядуурлын төсөл)  
*Simon Moss (Global Poverty Project)*

Хадсон Мтэга (Уитвотэрсрандын их сургууль)  
*Hudson Mtegha (The University of the Witwatersrand)*

Жералдинэ Мөрфи (Их Британийн Олон улсын хөгжлийн яам)  
*Geraldine Murphy (UK Department for International Development)*

Оуал (Рафсанжани) Муза (Хууль тогтоох нөлөөллийн иргэний нийгмийн төв)  
*Auwal (Rafsanjani) Musa (Civil Society Legislative Advocacy Centre)*

Фиона Напиер (Даян дэлхийн гэрч)  
*Fiona Napier (Global Witness)*

Жакоб Нэлл (Морган Стэнли)  
*Jacob Nell (Morgan Stanley)*

Стив Нго (Индонезийн эрчим хүч, ашигт малтмалын яам)  
*Steve Ngo (Ministry of Energy & Mineral Resources, Indonesia)*

Пэтгэр Нор (Норвегийн олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Норад)  
*Petter Nore (Norwegian Agency for Development Cooperation, NORAD)*

Ник Нортон (Ричмонд Аналитикс)  
*Nick Norton (Richmond Analytics)*

Норвегийн сангийн яам  
*Norway Ministry of Finance*

Кирсти Ноулан (Дэлхийн зөн интернэшнл)  
*Kirsty Nowlan (World Vision International)*

Крис Нерс (Харт групп)  
*Chris Nurse (Hart Group)*

Эд О'Киф (Синержи глобал консалтинг)  
*Ed O'Keefe (Synergy Global Consulting)*

Даниэл Пэйнтер (Их Британийн Олон улсын хөгжлийн яам)  
*Daniel Painter (UK Department for International Development)*

Крэйг Паск (Вуд Маккензи)  
*Craig Pask (Wood Mackenzie)*

Жефффри Питэрс (Фрешжилд брукхауз дэрингэр)  
*Geoffrey Peters (Freshfields Bruckhaus Deringer)*

Рассэл Пикард (Нээлттэй нийгмийн сан)  
*Russell Pickard (Open Society Foundation)*

Жозэф Пауэл (НЭГ)  
*Joseph Powell (ONE)*

Эдди Рич (Олборлох  
үйлдвэрлэлийн ил тод байдлын  
санаачилга)  
*Eddie Rich (EITI)*

Бэлинда Ричардз (Либерийн  
засгийн газар)  
*Belinda Richards (Government of  
Liberia)*

Алан Рой (Оксфордын  
бодлогын менежмент)  
*Alan Roe (Oxford Policy  
Management)*

Кэйт Руддок (Шэлл)  
*Keith Ruddock (Shell)*

Ридван Русли (Люксембургийн  
их сургууль)  
*Ridwan Rusli (University of  
Luxembourg)*

Радика Сарин (Төлснөө нийтэл)  
*Radhika Sarin (Publish What You  
Pay)*

Пол Сэгал (Сассексийн их  
сургууль)  
*Paul Segal (University of Sussex)*

Миначэ Шафик (Их Британийн  
олон улсын хөгжлийн яам)  
*Minouche Shafik (UK  
Department for International  
Development)*

Клэйр Шорт (Олборлох  
үйлдвэрлэлийн ил тод байдлын  
санаачилга)  
*Clare Short (Extractive Industries  
Transparency Initiative)*

Билл Синглтон (Канадын олон  
улсын хөгжлийн агентлаг)  
*Bill Singleton (Canadian  
International Development  
Agency)*

Рикардо Суарес дэ Оливэйра  
(Оксфордын их сургууль)  
*Ricardo Soares de Oliveira  
(University of Oxford)*

Майкл Стэнли (Дэлхийн банк)  
*Michael Stanley (World Bank)*

Жон Стронгман (Дэлхийн  
банк)  
*John Strongman (World Bank)*

Жеймс Сюзман (Дэ Беерс)  
*James Suzman (De Beers)*

Софья Свайр (Даян дэлхийн  
гэрч)  
*Sophia Swire (Global Witness)*

Мартин Тисн (Ил тод,  
хариуцлагатай байдлын  
санаачлага)  
*Martin Tisne (Transparency and  
Accountability Initiative)*

Пүрэвдорж Ваанчиг (Дэлхийн  
эдийн засгийн форум)  
*Purevdorj Vaanchig (World  
Economic Forum)*

Жастин Ван Рейн (Адам Смит  
Интернэшнл)  
*Justin Van Rhyn (Adam Smith  
International)*

Маринке ван Рит (Төлснөө  
нийтэл)  
*Marinke van Riet (Publish What  
You Pay)*

Кэти Уотсон (Синержи  
консалтинг)  
*Katie Watson (Synergy Global  
Consulting)*

Вивиан Вейцнер (Норд-Сауд  
хүрээлэн)  
*Viviane Weitzner (North-South  
Institute)*

Лейф Венар (Лондоны Кинг  
коллеж)  
*Leif Wenar (Kings College  
London)*

Жон Уэст (Нэгдсэн үндэсний  
байгууллагын хөгжлийн  
хөтөлбөр)  
*John West (United Nations  
Development Programme)*

Шамиль Еникеев (Оксфордын  
их сургууль)  
*Shamil Yenikeeff (University of  
Oxford)*

# БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ОДООГИЙН БОЛОН УРЬДЫН БҮХ АЖИЛЛАГСАД

Эндрю Бауэр  
*Andrew Bauer*

Фемке Брауэр  
*Femke Brouwer*

Хелен Демпси  
*Helen Dempsey*

Мэтт Женасци  
*Matt Genasci*

Макс Жорж-Вагнер  
*Max George-Wagner*

Александра Гиллис  
*Alexandra Gillies*

Патрик Хеллер  
*Patrick Heller*

Онтуан Хоити  
*Antoine Heuty*

Жон Иллэнкован  
*John Illankovan*

Дэниел Кауфман  
*Daniel Kaufmann*

Катарина Куай  
*Katarina Kuai*

Мари Линцер  
*Marie Lintzer*

Дэвид Михали  
*David Mihalyi*

Верити Аутрам  
*Verity Outram*

Маттео Пеллегрини  
*Matteo Pellegrini*

Роберт Питмэн  
*Robert Pitman*

Амир Шафай  
*Amir Shafaie*

Альпа Шах  
*Alpa Shah*

Алекс Тилли  
*Alex Tilley*

Варша Венагопал  
*Varsha Venugopal*

Эрика Уэстенберг  
*Erica Westenberg*

Жо Уильямс  
*Joe Williams*

## ЭХ БИЧИХ БАГ

Жим Каст

*Jim Cust*

Дэвид Мэнли

*David Manley*

## РЕДАКТОР

Ли Бейли

*Lee Bailey*

## ОРЧУУЛГЫН РЕДАКТОР

Н.Дорждарь

Д.Цэрэнжав

## ДИЗАЙН

Soapbox

([www.soapbox.co.uk](http://www.soapbox.co.uk))

[WWW.RESOURCEGOVERNANCE.ORG](http://WWW.RESOURCEGOVERNANCE.ORG)

[WWW.NATURALRESOURCECHARTER.ORG](http://WWW.NATURALRESOURCECHARTER.ORG)

## БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ТУНХАГИЙГ ДЭМЖИГЧИД



©2014

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

Хоёр дахь хувилбар



